



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020-X-N 50

Г.ЭНХТАЙВАН:
ФИНТЕКИЙН
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН
ОРЧНЫГ УЛАМ
БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХЫГ ЗОРИНО

ТӨЛБӨР
ТООЦООНЫ
ЦАХИМ ШИЛЖИЛТ

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
Deposit Insurance Corporation Of Mongolia



Finanzgruppe
Sparkassenstiftung für
internationale Kooperation



MBA
МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО

Дэлхийн хуримтлалын
өдөр - 2020

Хуримтлуулах
хялбархан



ТӨЛБӨРИЙН КАРТЫН ШИНЭ ТЕХНОЛОГИД ШИЛЖИНЭ

Манай улс “Төгрөг”-өөр нэрлэсэн үндэсний “₮” брэндийн төлбөрийн картыг анх 2012 онд зах зээлд нэвтрүүлсэн нь төлбөрийн системийн хөгжилд томоохон алхам болсон. Тэр цагаас хойш энэ оны байдлаар ₮ карт зах зээлийн 65.5 хувийг эзэлж, нийт 2.5 сая ширхэг карт гүйлгээнд хэрэглэгдэж байна. Энэхүү карт нь соронзон туузан дахь мэдээллийг уншиж гүйлгээ үүсгэдэг 1970 онд зохион бүтээгдсэн технологи юм.

Техник технологийн хурд нь цахим төлбөр тооцоонд хүчээ авч, хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэх болсон. Гэвч үүнийг дагаад мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэл нэмэгдэж буй нь хөгжлийн нэгэн сөрөг үр дагавар болж байна. Туузан технологийн хувьд тухайн карт эзэмшигчийн мэдээллийг хуулбарлах, хуурамчаар дуурайлган хэвлэх нь маш хялбар болж, олон улсад төлбөрийн картын залилан, хулгайн гүйлгээний 90 гаруй хувь нь хуулбарласан картаар үйлдэгддэг болжээ.

Үүнээс үүдэлтэй технологийн дараагийн шатанд гарах шаардлага үүсэж, ₮ картыг EMV чип технологид шилжүүлэх ажил манай улсад хийгдэж байна. Уг технологи нь мэдээллийн аюулгүй найдвартай байдлыг сайжруулснаас гадна ирээдүйд мобайл төлбөр тооцооны дэвшилтэд шийдлийг нэвтрүүлэхэд чухал алхам болох юм. Үүгээр зогсохгүй EMV чиптэй ₮ картыг хэрэглээнд нэвтрүүлснээр төлбөр төлөх, гүйлгээ хийх явц илүү хялбар, хурдан болно. Өөрөөр хэлбэл, зайнаас (NFC) уншуулж, мөнгөн дүнгийн тодорхой хязгаар дотор ПИН кодгүй гүйлгээ хийх, улмаар нийтийн тээвэр, авто машины зогсоол, зам ашигласны хураамж зэргийг хурдан, шуурхай хийх боломж хангагдана. Энэ нь арилжааны банкууд болон финтек компаниуд шинэ төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэх суурь бололцоог нээж өгч байна.

Үндэсний төлбөрийн ₮ картыг шинэчилж, нууцлал аюулгүй байдлыг сайжруулснаар иргэдийн бэлэн бус төлбөрийн хэрэгсэлд итгэх итгэлийг бэхжүүлнэ. Ингэснээр бэлэн бус төлбөр тооцоог нэмэгдүүлэх, цаашлаад гүйлгээний ил тод байдлыг хангах, татвараас зайлсхийх болон мөнгө угаах, далд эдийн засагтай тэмцэхэд өндөр үр дүн үзүүлэх юм.

Дээрх шинэ технологид суурилсан төлбөрийн картын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгийг Монголбанкнаас боловсруулж, олон улсад нийтлэг мөрддөг стандарт, журам, зааврыг нутагшуулахаар ажиллаж байна.



05

ОНЦЛОХ МЭДЭЭ

“ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР” АЯНЫГ ЭХЛҮҮЛЭВ



23

МОНГОЛБАНК ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Э.АНАР: ТӨЛБӨР ТООЦООНЫ 90 ХУВЬ НЬ ЦАХИМААР ХИЙГДЭЖ БАЙНА



07

ЯРИЛЦЛАГА

Г.ЭНХТАЙВАН: ФИНТЕКИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ УЛАМ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХЫГ ЗОРИНО



12

НИЙТЛЭЛ

ТӨЛБӨР ТООЦООНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТ



26

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ТӨЛБӨР ТООЦООГ ХИЙХЭД ХУВЬ ХҮНИЙ ДАХИН ДАВТАГДАШГҮЙ ШИНЖ БАЙДАЛД СУУРИЛДАГ БОЛНО



22

МОНГОЛБАНКНЫ МЭДЭЭЛЭЛ

10 ДУГААР САРЫН БАЙДЛААР 19.2 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА



29

БАНКИР

ЛИБРА, БИТКОЙН БОЛОН БУСАД САНХҮҮГИЙН ИННОВАЦИ НЬ ТӨВ БАНК ОРЧИН ҮЕИЙН ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТАЛААР АНХААРАХ ЦАГ БОЛСНЫГ САНУУЛЖ БАЙНА



33

СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ ГУРАВДАГЧ УЛС ОРНЫ ЖАГСААЛТ БА МОНГОЛ УЛС

2020.10.01 **"ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР" АЯНЫГ ЭХЛҮҮЛЭВ**



Монголбанк, Хадгаламжийн Даатгалын Корпораци, ХБНГУ-ын Шпаркасс банкны сан, Монголын Банкны Холбоо хамтран "Дэлхийн хуримтлалын өдөр 2020" аяныг "Хуримтлуулах хялбархан" уриатайгаар эхлүүллээ. Уг аяны хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, хуримтлалыг хэвшил болгоход хүүхэд залуучуудын дунд гар зураг, цахим орчинд Тик Ток видео, Мийм (Меме) зэрэг бүтээлийн уралдааныг зохион байгуулахаас гадна цуврал сургалт, уулзалтыг хийж, хуримтлалын ач холбогдлыг таниулан сурталчлах ажлыг зохион байгуулав.

2020.10.07 **ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ ШАГНАЛ ГАРДУУЛАВ**



"Халаасанд бус хэтэвчинд, овоонд бус хэрэглээнд" аяны хүрээнд иргэдийн үндэсний мөнгөн тэмдэгтэд хандах хандлага, түүний үнэ цэнийн талаарх ойлголтыг дээшлүүлэх, шинэлэг санал дэвшүүлж буй байдлыг хэлэлцүүлэх зорилгоор эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулав. Уралдаанд ирүүлсэн 300 гаруй бүтээлээс шалгаруулснаас тэргүүн байранд ЕБС-ийн математикийн багш Г.Мөнхзул, удаах байруудад Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Мөнхболор, сэтгүүлч, улс төр судлаач Б.Бадамцэцэг нар тус тус шалгарлаа.

2020.10.16 **МӨНГӨНИЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭВ**



Монголбанк 9 дүгээр сарын 25-ны өдөр УИХ-д өргөн барьсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл"-ийг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэв. Төрөөс Мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл нь ирэх онд Төв банкнаас дангаараа болон бусад төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлогын зорилтыг тодорхойлдог үндсэн баримт бичиг юм. Энэ жил тус хэлэлцүүлэгт олон улсын болон төрийн, төрийн бус байгууллагын төлөөллүүдийг түлхүү оролцуулан мөнгөний бодлогын ирэх жилд дэвшүүлсэн зорилтуудын талаар илүү нарийвчилсан мэдээллийг өглөө.

2020.10.16 **АХБ-НЫ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ МОНГОЛБАНКИНД ЗОЧИЛОО**



Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч ноён Павит Рамачандраныг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар ноён Павит Рамачандран Монгол Улсын эдийн засгийн ерөнхий төлөвтэй холбоотой шинэчилсэн тооцоо судалгааг танилцуулав. Харин Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн эдийн засгийн ирээдүйн төлөв, сорилтууд болон дунд хугацаанд хэрэгжих "Банкны шинэтгэлийн хөтөлбөр"-ийн үндсэн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчны шинэчлэлтийн талаар мэдээлэл өглөө. Энэ үеэр АХБ-аас банк санхүүгийн системийг шинэчлэн бэхжүүлэх, банкны дэд бүтцийг хөгжүүлэхэд хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

2020.10.21

МОНГОЛБАНКНЫ СТАТИСТИКИЙН ЦАХИМ ХУУДАС АШИГЛАЛТАД ОРЛОО

Төв банкнаас бэлтгэн гаргадаг мөнгө, санхүүгийн болон гадаад секторын статистик мэдээллийг олон нийтэд хэрэглэхэд хялбар, ойлгомжтой хэлбэрээр хүргэх зорилгоор Монголбанкны Статистикийн цахим хуудас (stat.mongolbank.mn)-ыг ашиглалтад орууллаа. Энэхүү цахим хуудас нь эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн дүрслэл, тоон мэдээллийг цаг хугацааны дарааллаар харуулж байгаа бөгөөд мөнгө санхүүгийн болон гадаад худалдааны тойм, зургийн багц, статистикийн сарын бюллетень, мэдээлэл тархаах хуваарь зэрэг бүхий л тоон мэдээлэл, танилцуулгыг цогцоор нь нэг дор багтааснаараа онцлог юм.

2020.10.23

МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН СААРАЛ ЖАГСААЛТААС ГАРЛАА

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын чуулга уулзалт 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр болов. Чуулганаар Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалт буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах талаар хэлэлцсэн юм. ФАТФ-ын Ерөнхийлөгч Доктор Маркус Плейер чуулганы дараах хэвлэлийн бага хурлын үеэр Монгол Улс саарал жагсаалтаас гарсныг албан ёсоор мэдэгдэв. Уг чуулганд 130 гаруй улс болон олон улсын байгууллагуудын төлөөлөгчид оролцож Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалтаас гаргах асуудлыг санал нэгтгэйгээр дэмжжээ. Мөн үеэр Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргасан явдалд баяр хүргэж, Ковид-19 цар тахлын хүнд хэцүү үед газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулсан нь олон улсын сайн туршлага болсныг онцлон тэмдэглэв.

2020.10.28

САНХҮҮГИЙН ЗАЛИЛАН ЛУЙВРААС БҮХ НИЙТИЙГ СЭРГИЙЛЭХ АЯНЫГ ЭХЛҮҮЛЭВ

Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдэд хувийн мэдээлэл алдагдвал учрах аюул занал, хохирлыг таниулах, цахим орчинд өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, залилах болон цахим гэмт хэрэгт өртөж болзошгүй иргэдийн тоо болон хохирлыг бууруулах зорилгоор “Ятгах тусам нягтал-2” аяныг гурван сарын хугацаанд хэрэгжүүлэхээр боллоо. Тус аяныг ЦЕГ, Монголбанк, Голомт банкттай хамтран хэрэгжүүлэх юм. Энэ хүрээнд иргэдийн хамгийн их хохирол амсаж буй олон улсын мөнгөн гуйвуулгатай холбоотой залилан, интернэт банк ашигласан цахим залилан, луйвраас хамгаалах, картын залилан луйвраас сэргийлэх, онлайн худалдааны аюулгүй байдал, пин кодны нууцлал, аюулгүй байдал зэрэгт хэрхэн анхаарч, мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах мэдлэг мэдээллийг нийгэмд түгээнэ.

Г.ЭНХТАЙВАН: ФИНТЕКИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ УЛАМ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХЫГ ЗОРИНО



Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайвантай Монгол Улсын төлбөрийн системийн өнөөгийн хөгжлийн чиг хандлагын талаар ярилцлаа.

Монгол Улсын төлбөрийн системийн хөгжлийг ямар түвшинд хүрсэн гэж та үзэх вэ?

Монгол Улсын төлбөрийн системийн хөгжил нь анх 1995 онд төлбөрийн хэрэгслийг хуульчилсанаас эхэлнэ. Түүнээс хойш тасралтгүй хөгжиж, өнөөдөр олон улсын түвшинд нэгэнт хүрсэн байна. Маш энгийн жишээнээс харахад л иргэд ямар ч төлбөр тооцоог хийхдээ аль нэг үйлчилгээний байгууллагад урт дараалал үүсгэх шаардлагагүй болж, цахим гүйлгээ нь бэлэн мөнгөний гүйлгээнээс ч илүү хэрэглээтэй болсон байна шүү дээ. Магадгүй таны хэтэвчинд бэлэн мөнгөнөөс илүүтэй төлбөрийн карт дор хаяж 2-3 төрлөөрөө, утсанд тань мөн 1-ээс илүүгүй банкны аппликейшн байгаа гэдэгт би л хувьдаа эргэлзэхгүй байна.

Тийм шүү. Тантай санал нэг байна.

Бодит байдал дээр ийм л байгаа. Цаашлаад жижиглэнгийн төлбөрийн системд төрөл бүрийн инновацлаг төлбөрийн үйлчилгээ, төлбөрийн хэрэгслийг бий болгоход гол нөлөөтэй Faster/Instant payment буюу агшин зуурын төлбөрийн системийг манай улс ашиглаж байна. Үндсэндээ 2014 оноос банк хоорондын төлбөр тооцоонд нэвтрүүлж эхэлсэн. Энэ системийг 2019 оны байдлаар дэлхийн 54 улсад ашиглаж байна гэсэн тоон мэдээ бий. Үүний тусламжтайгаар өнөөдөр манайд 3 сая төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ нь хүлээн авагчийн дансанд тэр даруй ордог болж, иргэд бэлэн бус төлбөрийн хэрэгсэл

ашиглах, технологийн компаниудын хувьд финтект түшиглэсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд том түлхэц болсон зэргээс үзэхэд бид дахиад ч цаашлаад улам боловсронгуй технологи руу цаг үеэ даган шилжээд байх боломжтой.

Тухайлбал, одоогийн байдлаар ямар дэвшилтэд шинэчлэлт рүү зорьж байна вэ?

Бид төлбөрийн системийн хөгжлийг дэлхийн түвшинд хүргэхээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтран төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд хэрэгжүүлж буй төлбөрийн системийн хууль эрх зүйн орчныг сайжруулах ажил 2015 оноос эхлэн хэрэгжиж байна. Тухайлбал, “Үндэсний Төлбөрийн Системийг хөгжүүлэх стратеги 2016-2020” баримт бичгийг боловсруулах, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсруулан батлуулах зэргийг нэрлэж болох юм. Цаашид бид дараагийн 5 жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулах, финтекийн хөгжлийг дэмжих зорилгоор Монголбанкнаас авч хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлохоор төлөвлөж байна.

Дараагийн нэг томоохон төсөл хөтөлбөр нь 2016 оноос АХБ-ны санхүүжилтээр Монголбанкинд хэрэгжүүлж буй “Төлбөрийн системийн шинэчлэл” төсөл юм. Үндэсний цахим гүйлгээний төвийн сүлжээ, техник хангамж болон дата төвүүдийн шинэчлэл,



банк хоорондын их дүнтэй (RTGS) болон бага дүнтэй төлбөрийн систем (ACH+)-ийн шинэчлэлийн ажлуудыг хийгээд байна. Одоо хийгдэхээр хүлээгдэж буй томоохон ажлаас дурдвал, үндэсний брэнд ₮ төлбөрийн картыг EMV/NFC технологийн чиптэй болгох, банк хоорондын бага дүнтэй болон картын системийн нууцлал, аюулгүй байдлыг хянах, удирдах шинэ систем нэвтрүүлнэ.

Олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжиж байгаа эдгээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр ямар үр дүн, гарах вэ?

Аливаа улсын төлбөрийн системийн хууль эрх зүйн орчин тодорхой байх нь маш чухал. Системийн хэмжээний олон эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болно гэсэн үг. Тийм ч учраас бид Дэлхийн банкны техник тусламжийн хүрээнд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг боловсруулж, 2017 онд батлуулсан. Энэ хуулиар Монголбанкнаас төлбөрийн системийг удирдан зохион байгуулах, хяналт тавих бүрэн эрхийг хуульчилж, үүнээс гадна төлбөрийн эцэслэлт, буцаалтгүй болгох, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн эрх зүйн орчныг баталгаажуулж өгсөн. Харин АХБ-ны

“Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг амжилттай хэрэгжүүлснээр төлбөрийн системийн тасралтгүй найдвартай ажиллагааг олон улсын жишгээр өндөр түвшинд хангах боломжтой болсон. Иргэдийн төлбөрийн системд итгэх итгэлийг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ, санхүүгийн хүртээмжийг тэлж, ингэснээр санхүүгийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж байна.

Сүүлийн үед санхүүгийн технологи буюу финтек гэж их ярих болжээ. Таны ярианд ч мөн хэдэнтэй дурьдагдлаа. Монголбанкнаас финтекийн хөгжлийг дэмжихэд хэрхэн анхаарч байна вэ?

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу арилжааны банкнаас гадна ББСБ, хуулийн этгээдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг нийт 9 хуулийн этгээдэд цахим мөнгө гаргах, төлбөрийн карт болон хөдөлгөөнт банкны процессорын үйлчилгээ эрхлэх, төлбөрийн карт хүлээн авах зэрэг үйл ажиллагааны хүрээнд зөвшөөрлүүдийг олгосон. Шинээр зөвшөөрөл авахаар бидэнд хүсэлт ирүүлж буй байгууллагын тоо ч буурахгүй байна. Бидний зүгээс цаашид финтек компаниудад зөвшөөрөл олгох, хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг илүү ойлгомжтой болгох шаардлага бий. Тиймээс холбогдох дүрэм, журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулж, зөвшөөрөл авахаар сонирхож буй байгууллагуудад дэлгэрэнгүй мэдээлэл өгөх зорилгоор Инновацийн төв байгуулахаар зорьж байна.

Монголбанк болон арилжааны банкуудаас бэлэн бус төлбөр тооцоог дэмжинэ гэж ярьдаг ч харилцагчдаас авдаг шимтгэл өндөр байна гэсэн гомдол их сонсогддог. Үүнийг бууруулах боломжтой юу?

Банкны тухай хуульд заасан эрхийнхээ хүрээнд арилжааны банкууд харилцагчаас авах шимтгэлээ өөрөө тогтоодог. Банкуудын мэдээлэл технологийн үйл ажиллагаа, нууцлал аюулгүй байдалд зарцуулж буй зардал өндөр байдаг. Хэрэв харилцагчаас авах шимтгэлийг тэглэх, хүчээр бууруулах зэрэг арга хэмжээ авсан тохиолдолд гүйлгээний болон харилцагчийн нууцлал аюулгүй байдлыг хангах, ашиглаж буй техник програм хангамжийг тогтмол шинэчлэх, сайжруулах зэрэг ажилд сөргөөр нөлөөлөх талтай.

Гэхдээ 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр иргэдийн интернэт банк, мобайл банкны хэрэглээг нэмэгдүүлэх, банкны салбар, тооцооны төвөөр үйлчлүүлэх харилцагчдын төвлөрлийг багасгах зорилгоор Монголбанкнаас банкуудыг банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг бууруулах уриалга гаргасан. Ингэснээр хөл хорионы хугацаанд шимтгэлийг 20-100% хүртэл бууруулах арга хэмжээг авсан. Цаашид бэлэн бус төлбөр тооцоог дэмжих зорилгоор харилцагчаас авах банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг дахин бууруулахаар банкуудтай хамтран ажиллаж тодорхой шийдэлд хүрсэн.

Дээрхээс үүдэн асуухад, Ковид-19 халдварын цар тахлын үед төлбөрийн системд ямар нөлөө үзүүлж байна вэ?

Банк хоорондын бага дүнтэй болон картын гүйлгээний тоо жил бүр тогтмол өсөлттэй байдаг. Жишээлбэл, 2019 онд 12.4 их наяд төгрөгийн 59 сая ширхэг бага дүнтэй гүйлгээ хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад гүйлгээний тоо 41 хувиар, 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 180 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Гэвч цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хөл хорионоос шалтгаалж худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг хязгаарлаж, иргэдийн орлого буурсантай холбоотойгоор 2020 оны нэгдүгээр улиралд бага дүнтэй гүйлгээний тоо буурч, өмнөх оны дөрөвдүгээр улиралтай харьцуулахад 26 хувиар багассан. Идэвхтэй ашиглагдаж байгаа картын тоо ч өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлынхаа 12.9 хувиар, 2019 оны 1-р улирлын үзүүлэлтээс 6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Харин 2020 оны хоёрдугаар улирлаас хөл хориог хэсэгчлэн сулруулж, үзвэр үйлчилгээний газруудыг буцаан нээснээр бага дүнтэй гүйлгээний тоо энэ оны нэгдүгээр улирлаас 71 хувиар, өмнөх оны хоёрдугаар улирлаас 7 хувиар тус тус нэмэгдсэн. Тэгвэл идэвхтэй ашиглагдаж буй картын тоо өмнөх улирлаас 9.3 хувиар, өмнөх оны хоёрдугаар улирлын үзүүлэлтээс 5.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна гэсэн статистик үзүүлэлт гарсан.

Энэ сард Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-аар батлуулна. Тус бодлогын баримт бичигт жил бүр төлбөрийн системийг хөгжүүлэхтэй холбоотой зорилтыг дэвшүүлдэг. Ирэх жилийн хувьд энэ хүрээнд юунд илүүтэй анхаарах вэ?

Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ гэсэн зорилт орсон. Эхний ажлын хувьд финтекийн хөгжлийг дэмжих зорилгоор одоогийн мөрдөж буй журам, дүрэм, бодлогыг сайжруулах, ингэснээр одоо үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа эхлүүлэхээр зорьж буй этгээдэд тавигдах шаардлага, үүрэг хариуцлага, хяналтыг илүү тодорхой болгоно. Мөн Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Монголбанкнаас төлбөрийн системд тавих хяналтыг үр ашигтай хэрэгжүүлнэ. Үүнээс гадна ₮ картыг олон улсын EMV стандарт хангасан чиптэй болгож, технологийн шинэчлэл хийх ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Ярилцсанд баярлалаа.

Б.Ариун (Төлбөр Тооцооны Газрын Бодлого зохицуулалт үйл ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн)

ЦАХИМ ТӨЛБӨР, ТООЦООНЫ ХӨГЖИЛ

Монгол Улсын төлбөрийн систем, тэр дундаа цахим төлбөр тооцоо, финтекийн салбарын хөгжлийн өнөөгийн түвшний талаар төлбөрийн системд оролцогч байгууллагуудын төлөөлөл байр сууриа илэрхийллээ.



“Мобифинанс” ББСБ-ын
Гүйцэтгэх захирал
П.ЦЭЭН-ОЙДОВ



“Хай Пэймэнт Солюшнс”
ХХК үүсгэн байгуулагч,
Гүйцэтгэх захирал
Б.НАРАНБАТ

Мобифинанс ББСБ нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу 2018 оны 9 дүгээр сард Монголбанкнаас “Цахим мөнгө гаргах” тусгай зөвшөөрөл авсан Монгол Улсын анхны цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч байгууллага юм. Хөгжлийнхөө эхэн үед бид харилцаа холбооны дэд бүтэц, технологид суурилан, цахим мөнгөний үйлчилгээг гар утасны дугаарт холбогдсон мобайл мони (mobile money) дансаа сим картад суусан STK цэс, мессеж болон NFC картаар удирдан төлбөр тооцоог хийдэг байсан. Харин ухаалаг утас болон дата хэрэглээ огцом нэмэгдсэн өнөө үед аппликейшнд суурилсан салбар хоорондын харилцан холболттой цахим хэтэвч бүхий үндэсний төлбөр тооцооны хэрэгсэл болон хөгжөөд байна.

Цахим хувьсал хурдацтай өрнөхийн хэрээр банк санхүүгийн байгууллагууд төдийгүй олон арван финтек компаниуд хялбар, шуурхай, өртөг багатай төлбөр тооцооны шийдлүүдийг зах зээлд нэвтрүүлж, өрсөлдөөн ч тэр хэрээр ихсэж байна. Гэвч хамгийн чухал шаардлага бол төлбөр тооцооны найдвартай, аюулгүй байдлыг хангасан дэд бүтэц, системтэйгээр хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалсан, хууль зохицуулалтын нийцлийг хангасан чанартай үйлчилгээг хүргэхэд билээ. Мобифинанс ББСБ нь мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2013 стандартыг хангасан, АСН+ автомат клирингийн системийн шууд холболттой төлбөр тооцооны суурь платформуор хэрэглэгчид, түншүүддээ бизнесийн ёс зүйтэй, хууль эрх зүйн нийцлийг хангасан үйлчилгээг хүргэн ажилладаг. Бид хэрэглэгчдийнхээ амьдралын хэв маягт нийцсэн Монпэй брэндийг 2020 оны 9 дүгээр сард зах зээлд танилцуулан, төрийн үйлчилгээний emongolia болон ebarimt системүүдтэй харилцан холболт хийж, улмаар сим картад суурилсан тоон гарын үсгийн үйлчилгээ, онлайн дэлгүүр, Монпэй маркет, нээлттэй эхийн код (open API), QR код зэрэг технологийн дэвшилтэт хялбар найдвартай төлбөр тооцооны шийдэл болон цахим санхүүгийн үйлчилгээнүүдийг нэвтрүүлээд байна.

|| Хай Пэймэнт Солюшнс” ХХК нь 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монголбанкнаас “Төлбөрийн карт хүлээн авагч” тусгай зөвшөөрөл авсан бөгөөд одоогоор арилжааны 12 банкнаас гадна тус зөвшөөрлийг эзэмшиж буй цор ганц финтек компани юм. Арилжааны банкуудын хувьд финтек компаниудыг хүлээн зөвшөөрөх, хамтран ажиллах хандлага нэмэгдсэн байна. Манай компанийн ойрын зорилго бол дэлхий дахинаа эрчимтэй хөгжиж буй онлайн худалдааг Монгол Улсад хөгжүүлэх, хялбаршуулах юм. Тиймээс онлайн худалдан авагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор өнгөрсөн хугацаанд Hi-Pay Wallet аппликейшнийг хөгжүүлж саяхан хэрэглээнд нэвтрүүлээ. Hi-Pay Wallet аппликейшн маань U Money картаа гар утсаараа цэнэглэх шинэ үйлчилгээг иргэддээ танилцуулаад байна. Түүнчлэн бидний хувьд тулгарч буй нэн тэргүүний бэрхшээл бол иргэд төлбөрийн картаар онлайн худалдан авалт хийхэд ашигладаг ePin кодоо мэдэхгүй байгаа явдал юм. Мөн иргэд банкнаас ePin кодоо шинээр авахад төвөгтэй удаашралтай байна. Одоогоор олон финтек компаниуд өрсөлдөж буй боловч ирээдүйд өөр хоорондоо уялдаатай ажиллан дундын дэд бүтцийг бий болгох замаар нэг QR уншигч ашиглах нь оновчтой шийдлийн нэг гэж харж байна.

Бидний зүгээс Монголбанкнаас хийгдэж буй картын системийн шинэчлэлийг хүлээж байгаа бөгөөд систем шинэчлэгдсэнээр PreAuthorization, ReCurrent зэрэг гүйлгээний төрөл нэмэгдэж, төлбөр тооцооны зах зээлд шинэ боломжууд нээгдэх юм. Цаашид Монгол Улсын төлбөр тооцооны зах зээлийг хөгжүүлэхэд финтек компаниуд болон арилжааны банкуудын нягт хамтын ажиллагаа нэн чухал юм. Учир нь харилцагчийн дансны суурь бүртгэл болон төлбөрийн картыг арилжааны банкууд хариуцдаг. Харин финтек компаниуд тухайн харилцагчийн данс болон төлбөрийн карт дээр суурилан олон төрлийн нэмэлт үйлчилгээг нэвтрүүлж, иргэдийн хэрэглээг хялбарчилах зарчимаар ажиллаж байна.



ТӨЛБӨРИЙН СИСТЕМ- 2020



ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ГЭЖ ЮУ ВЭ?

Иргэн, хуулийн этгээдийн хооронд мөнгөн хөрөнгийг шилжүүлэхэд оролцох байгууллага, ашиглах төлбөрийн хэрэгсэл ба техник, технологийн дэд бүтэц, эдгээрийг зохицуулсан хууль тогтоомжийг бүхэлд нь төлбөрийн систем гэнэ.



МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ИЙН ДЭД БҮТЭЦ

ИХ ДҮНТЭЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Монголбанк
Банксүлжээ
(RTGS)

Ажлын өдрүүдэд
(09:00-16:00)

3 сая төгрөгөөс дээш
дүнтэй банк хоорондын
гүйлгээ



БАГА ДҮНТЭЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

ҮЦГТ
Автомат клиринг хаус систем
(ACH+)

Өдөр бүр
24/7 цаг

3 сая төгрөг ба түүнээс
доош дүнтэй банк
хоорондын гүйлгээ



ТӨЛБӨРИЙН КАРТЫН СИСТЕМ

ҮЦГТ
Нэгдсэн систем

- Соронзон туузтай
- Чийптэй
- Зайн мэдрэгчтэй



МОНГОЛБАНК ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМД ХЭРХЭН ОРОЛЦДОГ ВЭ?

Үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлох

Төлбөрийн системтэй холбоотой зөвшөөрлийг олгох

Клирингийн болон төлбөр тооцооны систем ажиллуулах



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, шинээр төлбөрийн хэрэгсэл гаргах, төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдсон дүрэм, журам батлах, шийдвэр гаргах;

Зөвшөөрөл авсан этгээд, түүний төлбөрийн системд хамаарах үйл ажиллагаанд хяналт тавих

ТӨЛБӨР ТООЦООНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТ



Төлбөр тооцооны газрын ахлах мэргэжилтэн **А.Бат-Оргил**

Мэдээллийн технологи, ухаалаг утас, интернэтийн хурд эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед бэлэн бус төлбөр тооцооны олон төрлийн дэвшилтэд шийдлүүд бий болсоор байна. Өдгөө Англи, АНУ, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй оронд төлбөрийн картын мэдээллийг гар утас, бугуйвч, ухаалаг цаг, бөгж гэх мэт бидний өдөр тутам биедээ авч явдаг эд зүйлсэд суулгаж, төлбөр тооцоо хийх шийдэл бүхий мобайл төлбөрийн үйлчилгээ нэвтэрсээр байна. Үүнийг даган төлбөр төлөх, мөнгө шилжүүлэх үйл явц улам бүр хялбар болж, хэрэглэгчдийн төлбөр төлөх хэлбэр нь технологийг даган өөрчлөгдөж болжээ.

Банк, санхүүгийн салбар өндөр хөгжсөн орнуудын бэлэн бус төлбөр тооцооны дийлэнх хувийг дээр дурьдсан төлбөрийн картын системд суурилсан мобайл төлбөр тооцоо эзэлж байгаа бол банкны салбар, дэд бүтэц сул хөгжсөн хөгжиж буй орнуудад төлбөрийн картаас гадна цахим мөнгөний үйлчилгээ нэвтэрсэн байдаг. Ялангуяа хөгжиж буй орнууд буюу Африк, Зүүн Европын улсуудад үүрэн холбооны операторын сүлжээнд суурилсан цахим мөнгөний үйлчилгээ өргөн дэлгэрсэн. Үүний нэг жишээ нь Кени улсын М-песа гэх цахим мөнгөний үйлчилгээ юм.

М-песа нь Сафариком гэх Кенийн томоохон үүрэн холбооны оператор компаниас гаргасан, хэрэглэгчийн гар утасны дугаарт суурилсан цахим мөнгөний үйлчилгээ юм. Банкны

хүртээмж сул хөгжсөн учраас тус улсын иргэд банкинд хандан данс нээлгэх боломж тэр бүр байдаггүй нь энэ төрлийн цахим мөнгөний үйлчилгээ хөгжихөд дэмжлэг болсон гэж үздэг. Тус үйлчилгээ нь иргэдэд өөрийн гар утасны дугаарыг ашиглан төлбөр төлөх, өөр хоорондоо мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх, цахим мөнгөний данснаасаа бэлэн мөнгө авах, дансаа зузаатгах гэх мэт үйлдлийг хийх боломжийг олгодог. Иргэд тус үйлчилгээнд бүртгүүлэхдээ гэрээт төлөөлөгч гэх этгээд дээр очин бэлэн мөнгө тушааж гар утасныхаа дугаарыг бүртгүүлснээр тухайн иргэний цахим мөнгөний данс нь зузаатгагдаж, төлбөр тооцоо хийх эрх нь нээгддэг байна. Өдгөө Кени улсын хүн амын 93% нь цахим мөнгөний данстай байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь 50%-тай тэнцүү хэмжээний цахим мөнгө эргэлтэд гарсан гэх судалгаа байдаг.

Монгол Улсын хувьд бэлэн бус төлбөрийн хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа ч үүний дийлэнх хувийг төлбөрийн картын гүйлгээ, цөөн хувийг цахим мөнгөний гүйлгээ эзэлж байна. Монгол Улсад 2020 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 1.8 сая идэвхтэй төлбөрийн карт ашиглагдаж байгаа нь нийт 3.3 сая хүн амтай улсын хувьд маш өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн, идэвхтэй ашиглагдаж буй 1.8 сая картын 65%-ийг үндэсний брэнд ₮ төлбөрийн карт бүрдүүлж байна.

Цаашид Монголбанкны зүгээс банкуудтай хамтран ₮ картыг олон улсын EMV стандарт бүхий чип технологид шилжүүлэхээр ажиллаж, төстийн орчинд туршилтууд хийгдсээр байна. Төлбөрийн картыг чиптэй болгосноор дээр дурдсан хөгжингүй орнуудад хэрэгжсэн мобайл төлбөр тооцооны шийдлүүд манай улсад хэрэгжих үүд хаалга нээгдэх юм. Ингэснээр нийтийн тээвэр, авто зогсоолын төлбөр төлөх, элдэв төрлийн урамшууллын оноо цуглуулах, ашиглах, дебит болон кредит картын үйлдлийг зөвхөн ганц төлбөрийн карт ашиглан хийх боломжууд бий болно. Учир нь тус чип нь өөр дээрээ олон төрлийн үйлдэл хийх чадамжтай. Цаашлаад чип дээрх функцийг гар утас болон бусад ухаалаг төхөөрөмжүүдэд суулган ашиглах боломж бүрдэх юм.

Ирээдүйд дэлхийн зарим улсын төв банк цахим мөнгө гаргах талаар нэгэнтээ судалж эхэлжээ. Тухайлбал, Швед, Сингапур, Канад, БНХАУ нь энэ тал дээр эрчимтэй ажиллаж байна. Төв банкнаас цахим мөнгө гаргахад ямар загвар дээр суурилах, ямар технологи ашиглах, хэрхэн хяналт тавих, цаашид банк санхүүгийн салбарт гарч болзошгүй эрсдэлүүд гэх зэрэг тодорхойлох шаардлагатай олон асуудал байгаа тул албан ёсоор шилжилт хийсэн улс одоогоор зарлагдаагүй байна. Иймд хөгжиж буй орнууд энэ тал дээр ажигласан байр сууриас хандаж байна.



ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Монгол Улсын төлбөрийн систем нь банк хоорондын их дүнтэй "Банксүлжээ" (RTGS) төлбөрийн систем, бага дүнтэй "Автомат клиринг хаус" (ACH+) төлбөрийн систем болон төлбөрийн картын систем гэсэн гурван дэд системээс бүрддэг.



1 "БАНК СҮЛЖЭЭ" (RTGS)

Банк хоорондын их дүнтэй төлбөрийн систем буюу "Банксүлжээ" системээр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан 3 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ дамждаг бөгөөд тус систем нь гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж байна.



Ажлын
өдрүүдэд
09:10-16:30

2 "АВТОМАТ КЛИРИНГ ХАУС" (ACH+)

Бага дүнтэй төлбөрийн "Автомат клиринг хаус" (ACH+) системээр оролцогч хоорондын бага дүнтэй гүйлгээ буюу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан 3 сая төгрөг ба түүнээс доош дүнтэй гүйлгээ дамждаг бөгөөд тус систем нь гүйлгээг бодит цагийн горимд, 24/7 зарчмаар тасралтгүй дамжуулах, эсвэл багц болгож тодорхой давтамжийн дагуу дамжуулах сонголтыг оролцогч нарт олгодог.



Өдөр бүр
24/7 цаг

3 ТӨЛБӨРИЙН КАРТЫН СИСТЕМ

Төлбөрийн картын систем нь Монгол Улсад төлбөрийн үйлчилгээ эрхлэгч байгууллага хоорондын картын гүйлгээг дамжуулж, клиринг хийдэг бөгөөд тухайн өдөрт оролцогч хооронд хийгдсэн картын гүйлгээгээр үүсэн өглөг ба авлагын дүнг харилцан суутгах зарчмаар цэвэршүүлж, үр дүнг дараагийн ажлын өдөр "Банксүлжээ" системд дамжуулж, оролцогчдын дансанд тусгадаг.



Өдөр бүр
24/7 цаг



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... (2020.10.28)

Монголбанкны ээлжит хэвлэлийн бага хурал 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр болж, банк санхүүгийн салбарын статистик мэдээллийг танилцууллаа. Мөн энэ үеэр Монголбанкны удирдлагууд цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн асуултад хариулсан тэмдэглэлийг хүргэж байна.

Блүүмбэрг ТВ: Инфляц энэ он гарснаас хойш маш нам, дор түвшинд тогтож байна. Сарын өсөлтөөр нь харвал сүүлийн саруудад бүр дефляцтай гарсан. Монголбанкнаас энэ онд бодлогын хүүгээ 3 удаа, нийтдээ 3 нэгж хувиар буурууллаа. Гэсэн ч инфляц хэт нам дор түвшинд байсаар байгаа нь ямар шалтгаантай вэ?

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ГАЗАР (МБГ)-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

Мөнгөний бодлогын хүүг энэ жил 3 нэгж хувиар бууруулсан нь эдийн засгийн идэвхжлийг дэмжих дохиог зах зээлд өгсөн мөнгөний бодлогын төлөвийг илэрхийлж байгаа юм. Хамгийн гол нь инфляцын төлөв байдал, цаашдын хандлага нь төв банкны зорилтоос давахгүй гэсэн тооцоо, судалгаа байгаа учраас бодлогын хүүг бууруулах орон зайг бий болгож

байна. Нөгөө талаас шаардлагын хувьд эдийн засгийн уналтыг зогсоох, өсөлтийг дэмжих агуулгатай юм. Мөнгөний бодлогын шийдвэр гаргахдаа өнөөдрийн нөхцөл байдлаас гадна ирээдүйн төлөв байдлыг хардаг. Яагаад ирээдүйн төлөв байдлыг харж байна вэ гэхээр мөнгөний бодлогын хүүний нөлөөлөл нэг жилээс нэг жил хагасын хагацаанд бүрэн гарч дуусдаг гэсэн тооцоо, судалгаа бий. Тэгэхээр өнөөдрийн гарч байгаа гарч дуусна гэсэн үг. Төв банкны тооцоолж байгаагаар ирэх онд инфляц 6-аас ялимгүй бага, яг нарийвчилбал, 5.7 хувьтай гарах төсөөлөлтэй байна. Тэгэхээр ирээдүйн төлөв байдалд өнөөдрийн бодлогын хүүний түвшин нь харьцангуй нийцтэй байгаа юм. Энэ жилийн хувьд эдийн засгийн уналт төв банкны хүлээж байснаас өндөр гарсан нь бодлогын хүүг дараалан бууруулах шалтгаан болсон. Тэгэхээр өнөөдөр инфляцын түвшин бага байгаа ч ирээдүйд эдийн засгийн өсөлттэйгөө

уялдаад сэргэхээр байна. Инфляц буурахад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Нэгдүгээрт, эдийн засаг -9 хувийн агшилттай байгаа нь худалдан авалтаар дамжаад инфляцыг бууруулах нөлөөллийг үзүүлж байгаа бол хоёрдугаарт, нийлүүлэлтийн шинж чанартай бараа, бүтээгдэхүүнүүдийн өнгөрсөн жилийн суурь үеийн өндөр үнийн нөлөөлөл бий. Тухайлбал, он гарснаас хойш дэлхийн зах зээл дэх нефтийн үнийн өөрчлөлтийг дагаад дотоодын бензин, шатахууны үнэ хэд хэдэн удаа буурч, үүний инфляцыг бууруулж байгаа нөлөөлөл ирэх оны нэгдүгээр улирал хүртэл үргэжилнэ. Мөн улирлын онцлогийн дагуу зарим хүнсний бараа, бүтээгдэхүүний инфляц буурч байгаа. Тухайлбал, мах, хүнсний ногооны үнэ буурч байгаа нь инфляцыг бууруулах нөлөөлөл үзүүлж байна.

Төв банкны үнэт цаасны үлдэгдэл нэлээд өсөж байна. Тэгэхээр эдийн засгийг дэмжих бодлогууд байгаа онож байна уу?

МБГ-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

Төв банкны үнэт цаасны үлдэгдэл өсөж байгаа хоёр үндсэн шалтгаан байна гэж харж байна. Нэгдүгээрт, төсвийн алдагдал. Засгийн газраас төсвийг алдагдалтай баталж, санхүүжилтийг эдийн засагт хийж байгаа нь төв банкны үнэт цаасны үлдэгдлийг нэмэгдүүлж байна. Хоёрдугаарт, эдийн засгийн идэвхжил сул байгаа нь голлох нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, эдийн засагт мөнгө, зээлийн эрэлт бага болсон байна гэсэн үг. Банкны системээс гаргаж байгаа зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өсөлтгүй болж эхэлж байна. Статистикаар зээл -4 орчим хувийн агшилттай байгаа ч үүнд тэтгэврийн зээл тэглэсэн, орон сууцны зээлийг МИК бонджуулсан нөлөөлөл бий. Энэ хоёр шалтгааныг цэвэрлээд харвал, -4 биш 0 орчим хувьтай байгаа. Тэгэхээр зээлийн өрийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өсөлтгүй байна гэсэн үг. Энэ нь төв банкны үнэт цаасны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн.

NTV ТВ: Төлбөрийн тэнцэл он гарснаас хойш 9 сарын байдлаар 470 гаруй сая ам.долларын алдагдалтай болж, алдагдлын хэмжээ харьцангуй буурч байгаа. Тиймээс төлбөрийн тэнцлийн орох урсгал тал дээр томоохон дэмжлэг үзүүлж байгаа гол хүчин зүйл юу байна вэ?

СУДАЛГАА СТАТИСТИКИЙН ГАЗАР (ССГ)-ЫН ЗАХИРАЛ Б.БАТДАВАА:

Монгол Улсын төлбөрийн тэнцэл эхний 9 сарын байдлаар 472 сая ам.долларын алдагдалтай гарсан. Энэ оны тавдугаар сарын байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал 1.1 тэрбум ам.доллар байсан бол алдагдлын хэмжээ буурч 472 сая ам.доллар болсон. Алдагдлын хэмжээ буурах болсон шалтгаан нь нэгдүгээрт манай улсын барааны худалдааны ашиг сайжирч байна. Эхний 9 сарын байдлаар барааны худалдааны тэнцэл 1.2 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хорио цээрийн дэглэм тогтоосноор Монгол Улсын нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.8 сая тонн нүүрс буюу 900 гаруй сая ам.доллараар буурсан. Харин энэ алдагдлыг нөхөхөд Монголбанкинд тушааж байгаа алт болон алтны экспортын орлого томоохон нөлөө үзүүлж байна. Эхний 9 сарын байдлаар өнгөрсөн онтой харьцуулахад Монголбанкны экспортолж байгаа алтны хэмжээ 800 гаруй сая ам.доллараар нэмэгдсэн нь нүүрсний салбарын алдагдлыг алтаар нөхөж байна гэсэн үг. Нөгөө талаас санхүүгийн дансны хувьд хөрөнгө оруулалт 1.1 тэрбум ам.доллартай тэнцүү байна. Үүний дийлэнх нь Оюутолгойн хөрөнгө оруулалт юм. Хэдийгээр ХХБ-ны бондын эргэн төлөлт болон бусад өр, төлбөрүүдтэй холбоотойгоор 800-900 сая ам.долларын гадагшлах урсгал бий болсон ч нөгөө талдаа ОУВС-ийн хөтөлбөрийн дагуу орж ирсэн санхүүжилт болон АХБ, Дэлхийн банкнаас өгсөн санхүүжилтүүд нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлж байна. Түүнчлэн үйлчилгээний худалдаа буюу манай улсын гадагшаа төлдөг тээврийн зардал эхний 9 сарын байдлаар 350 орчим сая ам.доллараар буурсан. Үүний 170 орчим сая ам.долларыг нүүрсний тээврийн өртөг буурсантай холбож тайлбарлана. Мөн цар тахлын нөлөөгөөр бизнесийн гаднаас авах зөвлөх үйлчилгээний төлбөр 200-300 сая ам.доллараар буурсан нь төлбөрийн тэнцлийн алдагдал буурахад нөлөөлсөн.

Ийгл ТВ: Ханшийн статистик ямар байгаа вэ. Он гарснаас хойш төгрөгийн ханш долларын эсрэг 4 орчим хувиар суларсан. Мөн юанийн эсрэг бараг 10 хувиар сулраад байна. Тэгэхээр доллараас гадна юанийн ханш чангарч байгаа гол шалтгаан юу вэ?

НӨӨЦИЙН УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГАЗАР (НУСЗЗГ)-ЫН ЗАХИРАЛ А.ЭНХЖИН:

Төгрөгийн эсрэг ам.доллар он гарснаас хойш 4.3 хувиар чангарсан бол юанийн эсрэг нэлээдгүй хэмжээгээр суларсан. Төгрөгийн ханшийн хувьд цар тахалтай холбоотойгоор оны эхний хагаст нэлээд хүнд нөхцөлд байсан. Хоёрдугаар хагасаас эдийн засаг сайжирч, төлбөрийн тэнцлийн алдагдал буурч эхэлсэн. Ер нь төв банкны зүгээс ханш цаашдаа тогтвортой байх нь гэсэн хүлээлтэй байна. Аравдугаар сар гарснаас хойш төгрөгийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг чангарахад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Нэгдүгээрт, түрүүн хэлсэнчлэн эдийн засгийн нөхцөл байдал хоёрдугаар хагасаас сайжирч эхэлсэн. Нөгөө талаас гадаад орчинд таатай нөхцөлүүд гарч байна. Зэсийн ханш оны эхнээс 10 гаруй хувиар өссөн. Чулуун нүүрсний үнэ он гарснаас хойш харьцангуй тогтвортой, өндөр түвшинд хадгалагдаж байна. Алтны үнэ энэ оны байдлаар бараг 27 хувиар өссөн. Манай гадаад худалдааны гол түүхий эдүүдийн зах зээлийн үнэ гадаад худалдааны ашиг сайн байхад нөлөөлж байна. Энэ ч утгаараа төлбөрийн тэнцлийн алдагдал хоёрдугаар хагасаас хойш нэлээд буурсан. Нэмж хэлэхэд, Монгол Улс саарал жагсаалтаас гарсанд гадаад талдаа саарал жагсаалттай холбоотой гарч байсан хүндрэлүүд нааштайгаар шийдэгдэхээр байна. Сангийн яамнаас бонд гаргаж, ирэх онуудад хийгдэх байсан бондын төлбөрийг дахин санхүүжүүлэх асуудлыг шийдсэн. Ингэснээр 2021 оны хувьд “Мазаалай” бондын үлдэгдэл 130 орчим сая ам.доллар, бусад гадаадын байгууллагаас авсан зээл 60-70 сая ам.доллар гэж тооцвол Засгийн газрын гадаад өр төлбөрийн хэмжээ 200 орчим сая ам.доллар болж буурсан. Чингис бондын төлбөр 2022 оны арванхоёрдугаар сард хийгдэнэ. Энэ төлбөрөөс ч бас багагүй хэмжээнд бууруулсан. Тэгэхээр гадаад талдаа өр, төлбөрийн асуудал ирэх жилүүдэд харьцангуй тогтвортой байхаар шийдэгдлээ. Монголбанкнаас ч бас Хятадын ардын банктай байгуулсан своп хэлцлээ дахин 3 жилийн хугацаагаар сунгасан. Эдгээр хүчин зүйл нь цаашдаа ханш тогтвортой байх нь гэсэн хүлээлтийг үүсгэж байна. Юанийн ханшийн хувьд юань ам.долларын эсрэг он гарснаас хойш 8-9 хувиар чангарсан. Тэгэхээр Монгол Улсын хувьд юань ам.долларын эсрэг чангарч байгаа нь төгрөг юанийн эсрэг сулрах үндсэн нөхцөл болж байна.

Зууны мэдээ сонин: Чанаргүй зээлийн хувь хэмжээ өндөр байна. Мөн банкуудын зээл олголт буурч байгаа. Тэгэхээр зээл чанаргүйдээд байгаа учраас банкууд зээл олгохоо багасгаад байна уу?

ССГ-ЫН ЗАХИРАЛ Б.БАТДАВАА:

Банкны системийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ есдүгээр сарын байдлаар 11.4 хувьтай тэнцүү байна. Энэ үзүүлэлт сүүлийн 2-3 жилийн хугацаанд 10 орчим хувьтай байгаа. Тэгэхээр чанаргүй зээлийн хэмжээ огцом нэмэгдсэн зүйл байхгүй. Ялангуяа зээлийн өсөлт саарч байгаа буюу өмнөх оны үлдэгдэлтэй харьцуулахад -4.4 хувьтай байгаа энэ үед чанаргүй зээлийн үзүүлэлт тогтвортой байгаа нь сайн гэж бид үзэж байна. Чанаргүй зээл тогтвортой байхад Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах арга хэмжээ нөлөөлж байна. Эхний есөн сарын байдлаар ойролцоогоор 3 их наяд төгрөг буюу нийт зээлийн багцын 18 хувийн хүү болон үндсэн төлбөрт өөрчлөлт оруулсан гэсэн статистик бий. Энэ нь ойролцоогоор 56 мянга орчим зээлдэгчид хамаарах юм.

Блүүмбэрг ТВ: Алт-2 хөтөлбөрийн хүрээнд алт компаниудад хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн. Энэ хүрээнд хэчнээн хэмжээний санхүүжилт гарсан бэ, хэдэн компани хамрагдсан бэ?

НУСЗЗГ-ЫН ЗАХИРАЛ А.ЭНХЖИН:

УИХ-аас 2020 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр баталсан цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд Монголбанк, Засгийн газар хамтраад “Алт-2” хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд төв банкнаас хөнгөлөлттэй хүүтэй зээл олгож эхэлсэн. Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 11 аж ахуйн нэгж хөтөлбөрт хамрагдаж, 111 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан. Энэ санхүүжилт нь дотроо хоёр төрөлтэй. Нэг нь богино хугацаатай буюу урьдчилгаа төлбөрийн санхүүжилт юм. Энэ санхүүжилтийг алтны компаниуд ондоот багтаан эргүүлэн төлөх зохицуулалттай. Түүнчлэн урт буюу 2 хүртэлх жилийн хугацаатай, хөрөнгө оруулалтын санхүүжилт бий. Эдгээр арга хэмжээ нь дээрх хуультай нийцтэйгээр 2020 онд дуусгавар болно. Төв банкны үнэт металлын худалдан авалтын хэмжээ 10 дугаар сарын 20-ны байдлаар 18.9 тонн хүрсэн. Энэ нь

өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 орчим хувиар өссөн үзүүлэлт юм. Та бүхэн санаж байгаа бол 2019 онд Монголбанк нийтдээ 15 тонн үнэт металл худалдан авч байсан. Тэгэхээр 10 дугаар сарын 20-ны байдлаар 18.9 тонныг худалдан авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 4 орчим тонноор илүү байна. Монголбанк оны төгсгөл гэхэд нийт 21 тонн үнэт металл авах болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Энэ нь улсын гадаад валютын нөөцийг 1.2 тэрбум орчим ам.доллараар нэмэгдүүлнэ. Үндсэндээ чулуун нүүрсний экспортын орлогын хэмжээ нэлээд буурсан ч үүнийг Монголбанк алтны экспортын хэмжээгээр нөхөхөөр байна. Тиймээс экспортын хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 16 орчим хувиар буурсан дүр зураг ажиглагдаж байна.

Өнөөдөр сонин: Банкны тухай хуулиар банкны эзэмшлийн хувь хэмжээг хязгаарлахаар болсон. Энэ хуулийн зохицуулалтын талаар тайлбарлана уу?

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗАР (ХЭЗГ)-ЫН ЗАХИРАЛ Д.АЮУШ:

Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн нийт зохицуулалтын 15 хувь буюу 101 орчим заалтыг

хөндсөн байгаа. Үүний томоохон өөрчлөлтийн нэг нь банкны салбарын хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор нэг банкинд оруулах хөрөнгийн дээд хэмжээг 20 хувь гэж хязгаарлахаар санал оруулж байна. Өнөөдөр банкны салбарт нийтдээ 35 орчим их наяд төгрөгийн хадгаламж бий. Үүний 10 хувь нь эздийн буюу банкны эздийн хөрөнгө. Бусад нь хадгаламж эзэмшигчдийн хөрөнгө юм. Харин хөрөнгийн зах зээлд 2.5 орчим их наяд төгрөгийн хөрөнгө эргэлдэж байгаа. Тэгэхээр хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах энэхүү арга хэмжээ нь банкны засаглалыг сайжруулж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ гэж харж байна. Өргөн барьсан хуулийн төслөөр одоогийн банкууд 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа зарсан байх ёстой. Харин банкууд 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө хувьцаат компани болж, хөрөнгийн зах зээлд гарсан байна. Тэгэхээр бүх компаниуд нээлттэй компани буюу хувьцаат компанийн хэлбэртэй болно.




СТАТИСТИК МЭДЭЭЭЛЛИЙН ТОЙМ


2020 оны 9 дүгээр сарын статистик мэдээллийн тойм

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)




Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)



- Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өсөж 22.4 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 10.7 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 4.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, -1.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, -4.0 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна.
- M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.5 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 3.9 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор




Зураг 2.2. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл 17.2 их наяд төгрөг (төгрөгийн зээл 15.6 их наяд, гадаад валютын зээл 1.6 их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.2%-иар
- Хэвийн зээл өмнөх сараас 0.3%-иар буурч,
- Чанаргүй зээл өмнөх сараас 0.2%-иар
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 1.0%-иар өссөн байна.

2. Зээл /үргэлжлэл/

Зураг 2.3. Нийт зээл, гадаад валютын зээлийн эзлэх хувь




Зураг 2.4. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар




- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.5%-иар буурч 17.2 их наяд төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 5.6%-иар буурч 8.8 их наяд,
- Хувийн байгууллагынх 6.4%-иар буурч 8.0 их наяд төгрөгт тус тус хүрчээ.
- Нийт зээлийн 9.0%-ийг, иргэдийн зээлийн 1.0%-ийг, хувийн байгууллагын зээлийн 17.4%-ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

Зураг 3.1 Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр




Зураг 3.2 Ипотекийн зээлийн чанарын үзүүлэлт




- Тайлант сард банкууд 1,052 зээлдэгчид 77.3 тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 30.6% нь хөтөлбөрийн, 69.4% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.
- Ипотекийн нийт зээлийн үлдэгдлийн 73.6% нь хөтөлбөрийн зээл, 22.0% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 4.4% нь бусад эх үүсвэрээр олгосон зээл эзэлж байна.
- Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.3% нь хэвийн, 1.6% нь хугацаа хэтэрсэн, 3.1% нь чанаргүй зээл байна.
- Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 49.6%-ийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 49.3%-ийг хөтөлбөрийн зээл, 1.1%-ийг бусад эх үүсвэрийн зээл тус тус эзэлж байна.

4. Хүү

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламжийн хүү




Зураг 4.2. Нийт шинээр олгосон зээлийн хүү



- 2020 оны 9 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 10.0 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.0 хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурчээ.
- Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.4 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 11.0 хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээл өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна


*Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн өрсүүдийг оруулаагүй болно.

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2020 оны эхний 9 сар /урьдчилсан/




7. Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 7.1. Инфляцын хүлээлт



Зураг 7.2. Инфляцын хүлээлтийн тархалт



Олон улсын туршлагад тулгуурлан иргэд, ААН болон шинжээчдийн инфляцын хүлээлтийг улирал бүр тооцдог. 2020 оны IV улиралд явуулсан судалгаагаар иргэд инфляцыг 2021 оны III улиралд 4.2%, ААН-үүд 2.4%-тай байхаар хүлээж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 84%, бизнес эрхлэгчдийн 91% нь 2021 оны III улиралд инфляцын түвшинг 8%-аас бага байна гэж үзсэн.


Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа 2020 оны 10 сар, Монголбанк

7. Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 7.3. Иргэдийн эдийн засгийн төлөвийн хүлээлт



Зураг 7.4. Өрхийн санхүүгийн талаарх хүлээлт




2020 оны IV улиралд явуулсан түүвэр судалгааны дүнгээр эдийн засгийн чиглэлийн индекс өмнөх улирлын судалгааны дүнгээс сайжирч ирэх 1 жилийн хугацаанд “эдийн засгийн өсөлт өснө” гэсэн мужид гарлаа.

Иргэдийн дийлэнх нь ирэх нэг жилийн хугацаанд “өрхийн санхүүгийн байдал сайжирна” гэсэн эерэг хүлээлттэй байгаа бөгөөд чиглэлийн индексийг өмнөх улиралтай харьцуулахад сайжирсан байна.


Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа 2020 оны 10 сар, Монголбанк

8 ААН –ийн үнийн хүлээлтийн түүвэр судалгаа (Q4)

Зураг 8.1. Инфляцийн талаарх хүлээлт



Зураг 8.2. ААН-ийн өөрийн бүтээгдэхүүний үнийн хүлээлт



ААН-үүд богино хугацаанд (ирэх 3 сар) инфляц буурч, аажимдаа ирэх оноос (ирэх 12 сар) өсөх хүлээлттэй байна.

ААН-үүд өөрийн бүтээгдэхүүний үнийг богино хугацаанд (ирэх 3 сар) бууруулж, аажимдаа өсгөх (ирэх 12 сар) хүлээлттэй байна.



Үндэсний төлбөрийн ₮ карт нь соронзон туузанд суурилсан технологи ашигладаг бөгөөд энэ тохиолдолд картын мэдээллийг хуулбарлаж авахад хялбар байдаг. Хэрэглэгч картаа гээх, хулгайд алдах болон хуурамч картны залиланд өртөх үед нууцлал аюулгүй байдал алдагдах эрсдэл үүсдэг.

Иймд, технологийн үсрэнгүй хөгжлийн эрин зуунд ₮ картын нууцлал аюулгүй байдлыг сайжруулах зайлшгүй хэрэгцээ байгаа бөгөөд тус картыг дэлхий даяар өргөн хэрэглэгддэг EMV чип технологид шилжүүлэх нь нэн тэргүүний зорилт юм.



EMV ЧИП ТЕХНОЛОГИ БҮХИЙ ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН “₮-КАРТ”

EMV нь Европей, Мастеркарт, Виза гэсэн гурван байгууллагын нэрийн товчлол бөгөөд эдгээр нь EMV чип технологийг дэлхийн стандарт болгон хөгжүүлсэн байдаг. EMV стандарт нь нууцлал, аюулгүй байдлыг дээшлүүлж, дэлхий дахинд харилцан ажиллах техникийн стандартыг бий болгох бөгөөд ингэснээр төлбөрийн картуудыг тодорхой бүсчлэлд хүлээж авах боломж бүрдэнэ. Мөн энэ нь төлбөрийн картын дэд бүтцийг тоон болгох буюу зайнаас унших NFC технологи болон QR-Code төлбөр тооцоог нэвтрүүлэх эхний, чухал алхам болно.



2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН БАЙДЛААР 19.2 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА


10 дугаар сарын байдлаар 19.2 тонн үнэт металл худалдан авлаа

Монголбанк 2020 оны 10 дугаар сард 2.1 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 19.2 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.3 тн-р өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 19.2 тн үнэт металлын 17.5 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна.

2020 оны 10 дүгээр сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 102.1 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 114.6 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 1.6 тн үнэт металл худалдан авлаа.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 10 дугаар сард 174,145.46 төгрөг байлаа.

Үнэт металл худалдан авалтын сарын мэдээ



Дүрслэл 1. 2018-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)



Дүрслэл 2. 1990-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)


Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)



Дүрслэл 3. 2020 оны 10 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2020/10/30-ны хооронд 2,961.2 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1732 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



БИЛЕТ БАНКА РОССИИ
№ 1771050



Э.АНАР: ТӨЛБӨР ТООЦООНЫ 90 ХУВЬ НЬ ЦАХИМААР ХИЙГДЭЖ БАЙНА

Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анартай ярилцлаа.

Цахим төлбөр тооцоог түлхүү ашиглахын гол ач холбогдол, давуу талыг та хэрхэн тодорхойлох вэ?

Монголбанк цахим бэлэн бус төлбөр тооцоог бодлогоор дэмжин ажилладаг. Монголбанкны төлбөрийн системийн талаар баримтлах бодлогод мөн энэ талаар маш тодорхой заасан байгаа. Үүний дагуу олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих, бэлэн бус төлбөр тооцооны зардал хүндрэлийг бууруулах, суурь дэд бүтцийг сайжруулж шинэ техник, технологи нэвтрүүлж шинэлэг үйлчилгээ санал болгох зэрэг ажлыг хийж байна. Цахимаар төлбөр хийх мөн бэлэн бус төлбөр тооцоог ашигласнаар гардаг том давуу тал бол бэлэн мөнгөнөөс үүдэлтэй хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн эрсдэлүүд буурдаг.

Түүнчлэн цаг хугацааг хэмнэх төдийгүй бэлэн бусаар төлбөр

авч байгаа байгууллагуудын үйл ажиллагааны хурд нэмэгддэг. Тухайлбал, бэлэн мөнгөтэй харьцуулахад нэг төлбөрийг 2-4 дахин хурдан, картыг зайнаас уншуулсан тохиолдолд 10 дахин хурдан гүйцэтгэх боломжтой байх жишээтэй.

Тэгвэл монголчуудын хувьд төлбөр тооцооны энэхүү хувьслыг хэр өргөн хүрээнд ашиглаж байна вэ, сүүлийн жилүүдэд банкууд цахим технологийг хөгжүүлэхэд нэлээд анхаарах болсон. Гэвч нөгөө талдаа хэрэглэгчид уламжлалт байдлаар буюу банкинд очихыг илүүд үзэх тал байх шиг байна?

Банк санхүүгийн салбар алхам тутамдаа шинэ техник технологийг нэвтрүүлж өргөнөөр ашиглан хөгжүүлж байдаг. Тэр тусмаа төлбөр тооцооны хэрэгсэл дээр хамгийн сүүлийн үеийнхийг хэрэглэдэг онцлогтой. Сүүлд хийгдсэн судалгаагаар банкаар

дамжин өнгөрч байгаа бүх төлбөр тооцооны 90% нь цахимаар буюу төлбөрийн карт, интернэт мобайл банк гэх мэт сувгийг ашиглан зайнаас хийгдсэн байгаа бол үлдсэн ердөө 10% л банкны салбар дээр, теллерээр дамжиж байна гэсэн үр дүн гарсан. Үүнээс харахад банкны төлбөр тооцоо Монгол Улсын хэмжээнд бараг бүрэн цахимжсан гэж хэлж болно. Тийм ч учраас манай банкууд мэдээллийн технологийн салбарт маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийж ирсэн. 2019 онд банкууд нийт 222 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг зөвхөн мэдээллийн технологийн хөгжүүлэлт, засвар үйлчилгээнд зориулсан байх жишээтэй. Одоогоор уламжлалт байдлаар буюу банкны салбарт биеэр очиж авдаг нэгэн төрлийн үйлчилгээ үлдсэн нь тэтгэвэр тараалт байгаа юм. Энэ нь тус үйлчилгээг авдаг тэтгэврийн насныхны онцлог байдлаас хамаарч буй асуудал гэж харж

байна. Карт ашиглах нь насаараа бэлэн мөнгө ашиглаад сурчихсан тэдэнд АТМ-тай харьцах нь төвөгтэй, мөн пин кодоо мартаж, бусдад залилуулах магадлал өндөр гэх мэт сонор сэрэмж талаасаа эрсдэлтэй байж болох юм. Нөгөө талаасаа банкныханы хэлдэгээр үеийнхэнтэй уулзаж, хууч хөөрөх боломж энэ үеэр тохиодог бололтой.

Иргэдийн хувьд төрийн үйлчилгээний төлбөр тооцоог авах гэж дараалалд урт хугацаанд зогсох цагаа алдах нь бий. Үүнийг шийдэхийн тулд И-Монголиа цахим порталыг Монголбанктай хамтран хэрэгжүүлж эхэлсэн шүү дээ. Манай уншигчдад мэдээлэл болгож хэлэхэд, үйлчилгээг хэрхэн хялбарчилсан бэ?

Таны хэлж буй хүндрэл бэрхшээлийг шийдэхийн тулд төрийн үйлчилгээний төлбөрийг картаар төлөх, Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн системээр гүйлгээг дамжуулах ажлыг Монголбанкнаас гүйцэтгэсэн. Үр дүнд нь 2018 оноос Дүнжингарав худалдааны төв дэх төрийн нэг цэгийн үйлчилгээнд Төрийн банктай хамтран карт хүлээн авах ПОС төхөөрөмж байршуулж, үйлчилгээ авсан даруйдаа картаар төлбөр хийх боломжтой болгоод байна. Нийслэлд хамаарах бүхий л хураамж болон тээврийн хэрэгслийн ухаалаг үйлчилгээний smartcar.mn цахим хуудасны гүйлгээ манай системд холбогдсон. Мөн засгийн газраас хэрэгжүүлж байгаа И-Монгол төслийн хүрээнд


Монголбанк Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллаж 10 дугаар сараас эхлэн төрийн үйлчилгээний цахим порталын 181 төрлийн үйлчилгээний төлбөрийг картаар төлөх боломжийг бүрдүүлсэн. Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажлыг үргэлжлүүлэн хийж байгаа.

2020 ОНЫ АРАВДУГААР САРЫН 29-НИЙ БАЙДЛААР 520 ИРГЭН ИПОТЕКИЙН 6 ХУВИЙН ЗЭЭЛД ХАМРАГДАВ

Орон сууцны ипотекийн жилийн 6 хувийн хүүтэй зээлийг энэ оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хойш хүсэлт гаргасан иргэдэд олгож эхлэх зохицуулалттайгаар хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 29 –ний өдрийн байдлаар нийт 520 иргэнд 37.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монголбанк болон арилжааны банкны эх үүсвэрээр олгоод байна. Үүнээс хөдөө орон нутгийн 145 зээлийн хүсэлтэд 7.8 тэрбум төгрөгийн зээлийг олголоо.



ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 30/Х ӨДРИЙН БАЙДЛААР)



ТӨЛБӨР ТООЦООГ ХИЙХЭД ХУВЬ ХҮНИЙ ДАХИН ДАВТАГДАШГҮЙ ШИНЖ БАЙДАЛД СУУРИЛДАГ БОЛНО

Орчуулсан: **Б.ХОСБАЯР** (Төлбөр тооцооны газрын ахлах хянан шалгагч)

Дэлхий дахинд бараа бүтээгдэхүүний худалдан авалтын төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын арга хэлбэр нь сүүлийн жилүүдэд хурдацтай өөрчлөгдөж байна. Интернет болон дэвшилтэт технологи дээр суурилсан ухаалаг тоног төхөөрөмжүүд, хиймэл оюун ухааныг ашиглаж төлбөр тооцоог хурдан шуурхай, найдвартай хийж байна. Энэхүү хувьсгалыг дагаад уламжлалт төлбөр тооцооны хэв маяг цахим хэлбэрт шилжин өөрчлөгдсөн бөгөөд цаашид ч хурдацтай хөгжих салбаруудын эгнээг тэргүүлж байна. Цахим төлбөрийн технологи нь өмнөх 4-5 жилийн хугацаанд хурдацтай хөгжсөн ч ирэх онуудад бүр илүү томоохон дэвшилд хүрэх хандлагтай байна.

БИОМЕТРИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ



Биометрийн баталгаажуулалт нь хувь хүний дахин давтагдашгүй хэв шинжийг ашиглаж тухайн хэрэглэгчээ таних арга хэлбэр юм. Тухайлбал, хурууны хээг унших, нүүр царай таних, зүрхний цохилтыг шинжилж хэрэглэгчийг хормын төдийд таньж төлбөр тооцоог нь баталгаажуулан гүйлгээ хийгдэх боломжийг олгож байна. VISA компанийн хэрэглэгчдээс авсан судалгаанд нь биометрийн баталгаажуулалт нь нууц үг эсвэл ПИН-ээс илүү аюулгүй бас хялбар гэж үзжээ. Учир нь төлбөрийн карт уншуулах бас цахим банкинд нэвтрэхийн тулд нууц үг эсвэл ПИН кодоо санах шаардлагагүй болох юм.

ЦАХИМ ХЭТЭВЧ



Ухаалаг гар утасны хэтэвчний тусламжтайгаар мөнгө хүлээн авах, төлбөр төлөх, мөнгөн шилжүүлэг хийх, зээл авах, зээл эргэн төлөх, бэлэн орлого хийх зэрэг санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг хийх боломжтой.

“Statista” байгууллагын судалгаагаар “Apple Pay” -ын цахим хэтэвчийг 2018 онд дэлхий дахинд 140 сая хэрэглэгч ашиглаж байсан бол 2020 оны байдлаар нийт 227 сая хэрэглэгчтэй болсон байна. Мөн “Samsung Pay” 2018 оны байдлаар 51 сая хэрэглэгчтэй байсан бол 2020 онд 100 гаруй сая хэрэглэгчтэй болсон. “Google Pay” -ын хэрэглэгчид 2018 онд 39 сая 2020 он гэхэд 100 гаруй сая болж нэмэгджээ. Ирэх жилүүдэд илүү олон компани өөрсдийн өвөрмөц цахим түрийвчийг бий болгож, дэлхийн хэмжээнд цахим хэтэвчийн хэрэглэгчдийн тоо тогтвортой өсөх хандлагатай байна.

NFC ЗАЙНААС УНШИХ ТЕХНОЛОГИ



Зайнаас уншиж гүйлгээг баталгаажуулан гүйцэтгэх технологи нь хурдацтай өсөж буй төлбөр тооцооны арга хэлбэрийн нэг юм. Энгийн картаар төлбөр тооцоо хийхээс илүү хурдан бөгөөд хялбар. Тус технологийн хамгийн өргөн хэрэглээ бол нийтийн тээвэрт ашигладаг бөгөөд дэлхийн томоохон хотууд нийтийн тээвэр, галт тэрэгний зогсоолуудад болон өдөр тутмын бага дүнтэй гүйлгээнд өргөн ашиглагддаг. Statista байгууллагын хийсэн судалгаагаар 2020 оны байдлаар NFC технологийн зах зээл 20.3 тэрбум ам.доллараар хэмжигдэж байгаа бол 2024 оны байдлаар нийт 47.3 тэрбум ам.доллар болох таамагтай байна.

ХУБИЛАЙ
ХААН
МАРКО
ПОЛОГИЙН
ХӨРӨГТЭЙ
300С



Он: 2003

Нэрлэсэн үнэ: 500 төгрөг

Металл: Мөнгө 925

Жин: 25 гр

Голч: 38.61 гр

Нүүр тал: Төв хэсэгт Хубилай хаан болон Марко Пологийн хөрөг, 4 хэлээр бичигдсэн хүрэл пайз зэргийг товойлгон дүрсэлсэн. Дээд хүрээгээр "Khubilai Khaan", "Marco Polo" гэж англиар, "1275-1292" гэсэн бичвэр болон оныг араб тоогоор бичсэн.

Ар тал: Монголбанкны эмблемний хоёр талд "Монгол", "Улс" гэж Монгол бичгээр, доод талд нь нэрлэсэн үнэ, оныг араб тоогоор, "Mongolia 25 gr, 925 SILVER" гэж англиар тус тус бичжээ.



Зургийг Карин Кофер

Олон улсын Төлбөр тооцооны Банк
Агустин Карстенст:

ЛИБРА, БИТКОЙН БОЛОН БУСАД САНХҮҮГИЙН ИННОВАЦИ НЬ ТӨВ БАНК ОРЧИН ҮЕИЙН ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТАЛААР АНХААРАХ ЦАГ БОЛСНЫГ САНУУЛЖ БАЙНА

Neue Zürcher Zeitung хэмээх Германы өдөр тутмын сонинд 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Олон улсын төлбөр тооцооны Банкны Ерөнхий менежер Агустин Карстенстай сэтгүүлч Томас Фустер болон Кристоф Исенриг нарын хийсэн ярилцлагыг толилуулав байна. 2020/10/12

“Корона хямрал”-аас шалтгаалан, олон орны бодлогын хүүний түвшин “0” эсвэл бүр хасах утгатай байна. Үүнээс болж төв банк нөөц, орон зайгаа барж байна уу?

Хүүний түвшинг харвал зарим хүмүүс тэгж ойлгож магадгүй, гэвч хангалттай орон зай байгаа шүү дээ. Ийм үед төв банкууд өөрсдийн баланс, тайлан тэнцэлээ ашиглаж илүү бүтээлчээр хандах хэрэгтэй. Цар тахлын эдийн засагт үзүүлж буй үр дагаврын хариуд төв банк бонд худалдан авч түүнийг шууд жижиг дунд бизнесийг дэмжих санхүүжилт болгон гаргаж байна. Үүнээс гадна төв банкны олон нийттэй харилцах харилцаа ирээдүйн бодлогын хүүний түвшинд буюу хүлээлтэд нөлөөлж чадна.

Гэвч хэрэв төв банк хувийн компаниудыг шууд санхүүжүүлнэ гэвэл энэ нь тодорхой хэсэгт л дэмжиж байна гэсэн үг. Төв банк төвийг сахих ёстой биш гэж үү?

Асуудлууд даамжрах нь бодлогын уламжлалт бус хэрэгслүүдийг ашиглах шаардлагыг дагуулдаг. Төв банк үүн дээр аз туршихгүй байх нь зүйтэй. Гэвч нөхцөл байдал маш хүнд байгаа учир бид оролцож байна. Үнэндээ мөнгөний бодлогын хувьд “улаан шугам”-ыг аль хэдийн давчихаад байгаа шүү дээ. Гэхдээ бид эрсдэлийг бүрэн тооцоолж ажиллаж байгаа, энэ зарчмаараа явах нь чухал юм.

Таны хувьд “улаан шугам” гэж юуг хэлж байна вэ?

Бодлогын хүү сөрөг утгатай байна шүү дээ. Миний оюутан байх үед ийм явдал тохиолдсон бол итгэхэд ч бэрх байх байсан. Онолын хувьд энэ бол “улаан шугам” юм. Нөгөө талаар төв банк засгийн газрын бондыг шууд худалдан авч байгаа нь үүний бас нэг жишээ болно.

Гадаад валютын худалдан авалтын үр дүнд, Швейцарын Ардын банкны нийт нөөц эдийн засгийн бүтээмжийнхээ 130%-

тай тэнцээд байгаа. Төв банкны хөрөнгийн балансад ямар нэгэн хязгаар гэж байдаггүй юм уу?

Ямар ч зүйл байнгын өсөлттэй байна гэж байхгүй. Гэвч, Швейцар франкны эрэлт байсаар байвал Швейцарын Төв банк үүний дагуу ажиллах нь тодорхой. Хэрэв энэхүү эрэлтэд хүрэхгүй бол Швейцар франкны ханш огцом чангарна. Энэ нь эргээд Швейцарын эдийн засагт өрсөлдөх чадвараар дамжуулж ихээхэн хохирол учруулна.

Хэрэв төв банк айл өрх, аж ахуй нэгжүүдэд шууд мөнгө тараадаг байсан бол та улаан шугамыг давж "нисдэг тэрэг"-ээр мөнгө тараах байсан уу?

Зарчмын хувьд бид үүнийг үгүйсгэж чадахгүй. Нөгөө талаас бид хэзээ ч ийм байдалд хүрэхгүй байх гэж найдаж байна. Дефляци нүүрлээд ирвэл гол нь юу ч хийхгүй байх нь илүү аюултай байх болно.

Энэ үе ирчихээд байна уу?

Үгүй ээ, хараахан тийм биш.

Швейцарын Ардын Банк олон жилийн турш гадаад валютын захад хэт оролцож байгаа. Иймээс Швейцар "валютын тохируулагч" болоод байна уу?

Би тэгж бодохгүй байна. Швейцарын Төв банк валютын ханшийг онилдоггүй. Дэлхий нийтээр мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж байгаа нь Швейцарын франкны эрэлт үүсэх дам нөлөө болсон. Гэвч, Швейцарын эдийн засагт энэ бүх урсгалыг шингээх орон зай хангалттай байхгүй. Тиймээс Швейцарын Ардын Банк сөрөг арга хэмжээг авч байна. Гадаад валютын худалдаа бол хамгаалалтын арга хэмжээ юм.

Сүүлийн жилүүдэд мөнгөний бодлогын тэгш бус байдал их байсанд гол асуудал байгаа юм. Огцом давлагааны үед маш хурдан сайжирч болох боловч эргээд сэргэх үедээ жолоогоо татахгүй орхичихдог.

Энэ бүхний үр дүнд, төв банк инфляцыг нам дор, тогтвортой түвшинд барьж чадаж байгаа. Тиймээс бид

төв банк мөнгөний бодлогын стандартыг гажуудуулсан гэж хэлж чадахгүй. Нөгөөтэйгүүр, төв банк шаардлагатай үед жолоогоо татах боломжоо тухай бүр ашиглах ёстой. Гэвч боломж тийм ч их байгаагүй.

Холбооны Нөөцийн банк стратегидээ тохируулга хийсэн. Европын Төв банк ч ийм хүлээлттэй байгаа. Аль аль нь богино хугацаанд инфляцыг 2%-иас дээш гарахыг хүлээн зөвшөөрч байна. Энэ тал дээр таны бодол?

Энэ бол "нарийн-тохируулга" юм. Эдгээр улсуудад инфляцыг хэн ч 5%-д хүргэхийг хүсэхгүй нь мэдээж. Одоогоор 2%-ийг онилж байна. Гэвч яг зорилтдоо хүрнэ гэдэг тийм ч амар биш. Тиймээс Холбооны Нөөцийн банк 2%-ийн дундажыг зорилтоо болгож байгаа юм.

Холбооны нөөцийн банк болон Европын төв банк инфляцыг нэг түвшинд бус тодорхой хязгаарт тогтоосон нь ухаалаг шийдвэр байсан уу?

Энэхүү интервал нь үндэслэлтэй. Гэхдээ ийм үед инфляцын зангуу буюу хүлээлтийг удирдахад бэрхшээлтэй болдог хэмээн зарим хүмүүс шүүмжилдэг. Намайг Мексикийн Төв банкны ерөнхийлөгч байх үед хүүний түвшин 3% +/-1 нэгж хувь байсан. Энэ зорилтоо ч сайн биелүүлсэн. Төв банкууд стратегиа өөрчилнө гээд үндсэн зорилт болох үнийн тогтвортой байдлыг хангах бодлогоо хэрхэвч өөрчилж болохгүй.

Сүүлийн хэдэн сар ам.доллар суларч байгааг бид харж байна. Энэ нь дэлхийн нөөцийн валютаас ам.доллар хасагдаж буйн эхлэл мөн үү?

Үгүй, тийм зүйл болох болоогүй. Ам.доллар голлох валют хэвээр байгаа. Дэлхийн эдийн засагт ам.долларын санхүүжилт маш чухал. Дэлхийн санхүүгийн системийг тогтвортой байдлын төлөө Холбооны нөөцийн банк их хэмжээний ам.доллар нийлүүлэх шаардлагатай болсон. Холбооны нөөцийн банк валютын ханшийг мөнгөний бодлогын зорилтоо болгодоггүй. АНУ-ын мөнгөний зөөлөн бодлого нь ам.доллар сулрахад нөлөөлж байна. Гэвч энэ нь ирээдүйд ам.долларын үүрэг буурна гэсэн хүлээлтийг нэмэгдүүлж, эрэлтийг бууруулна гэсэн үг огтхон ч биш юм.



Зургийг Томас Трасчел

Гэвч АНУ-ын Засгийн газрын өрийн хэмжээ хурдтайгаар өсч байгаа бөгөөд 2021 он гэхэд анх удаагаа ДНБ-ээс давахаар байгаа. Энэ нь өөрөө ам.долларын ноёрхлыг нураахгүй гэж үү?

Үгүй. Ам.доллараар хөрөнгө оруулалт хийх сонирхол маш их бий. АНУ-ын өрийн хэмжээг нөгөө талаар өрийн багтаамж гэж ойлгох хэрэгтэй. Америкт татварын дарамт харьцангуй бага. Хэрэв энэ улсад нэмэлт санхүүжилт хэрэгтэй болбол нөөц хангалттай байгаа гэсэн үг.

Зөвхөн АНУ гэлтгүй дэлхий даяар улс орнуудын өрийн хэмжээ нэмэгдсээр байна. Энэ нь эргээд төв банк бодлогын хүүгээ өсгөх орон зайг хумьж байна. Тэгэхээр улс орны төв банк нэн тэргүүнд эдийн засгаа аварч үлдэх үе ирээд байна уу?

Та "сангийн ноёрхол" гэсэн асуудлыг хөндлөө. Хэрэв энэ зүйл болно гэвэл, мөнгөний бодлогыг тодорхойлоход сангийн бодлогыг мөнгөний бодлогоос дээгүүр тавих шаардлага бий болно. Гэхдээ бид ийм нөхцөл байдалд хүрэх харахан болоогүй байна. Мэдээж зарим улс орны төв банк засгийн газрын өрийг худалдаж авч байгаа. Энэ нь хүнд нөхцөл байдалд буй орнуудад туслах түр зуурын үзэгдэл. Учир нь энэ оны эхэнд болж буй үйл явдал яг л "дайн" шиг байна.

Яагаад тэр билээ?

Дайны үед, аливаа улс зардлаа маш хурдан нэмэх шаардлага тулгардаг. Мэдээж зах зээл нь нэмэлт өрийг тийм ч хурдан шингээж чадахгүй. Ийм үед, төв банк санхүүгийн системийн тогтворгүй байдлаас сэргийлэхийн тулд оролцох шаардлага үүснэ.

Гэхдээ төв банк засгийн газрын өрийг зогсолтгүй худалдан аваад байж чадахгүй. Түүхэнд ийм үйл явдал сайнаар төгссөн удаагүй.

Үүнд бусад институциудын үүрэг оролцоо маш чухал. Төв банк ямар ч үед "Одоо хангалттай" гэж хэлж чаддаг байх ёстой. Төв банкнаас ч юуг яагаад хийж байгаагаа болон тэдний үйл ажиллагааны хязгаар юу болохыг үргэлж тайлбарлаж байх ёстой. Английн Төв банкны жишээг харъя. Засгийн газрын шууд санхүүжилтийг 4 дүгээр сард батлахдаа энэхүү онцгой шийдвэрийг яагаад гаргасан шалтгаанаа маш тодорхой тайлбарласан байдаг.

Английн төв банк энэ бол зөвхөн "түр зуурын арга хэмжээ" гэдгийг хэлсэн. Гэвч улс төрчид "хэрэв нэг удаа хийсэн бол хоёр дахь удаа хийх л болно" гэж хэлнэ.

Харин төв банк хүч чадлаа харуулж "хоёр дахь удаа гэж байхгүй" болохыг ойлгуулах хэрэгтэй.

Энэ хямрал олон орны өрийг их хэмжээгээр нэмэгдүүлж байна. Дэлхийн санхүүгийн системийн ноцтой хямралд орох хүртэл энэ хэр удаан үргэлжлэх боломжтой вэ?

Дэлхийн санхүүгийн системийн эрсдэл нэмэгдсэн гэдэг нь маргаангүй үнэн. Энэ бол маш тодорхой. Түүхээс харахад өрийн хэмжээ их байх тусам санхүүгийн хямрал ч тэр хэмжээгээр өндөр байдгийг бид мэднэ. Тийм л учраас төв банк санхүүгийн тогтвортой байдалд илүүтэй анхаарсаар байна. Эрсдэлүүдийг илүү удирдахын тулд нэмэлт тооцоолуудыг хийх шаардлагатай.

Ямар төрлийн тооцоолууд вэ?

Жишээлбэл, банк бусын салбар дахь санхүүгийн хэрэгсэл болох мөнгөний захын санхүүжилт гэж байдаг. Энэ нь өрийн хэрэгсэлтэй нэг доор зах зээлд их хэмжээгээр орших боломжтой. Эдгээр санхүүжилт нь хүүний өөрчлөлтөд мэдрэг боловч одоогоор зохицуулалтгүй байсаар байна. Тэгэхлээр хүү хэлбэлзэж эхлэх үед өрийн хэрэгсэл зардалтай тул эдгээр хэрэгслийг хязгааргүйгээр авах боломжтой байдаг. Иймд энэ төрлийн хэрэгслүүдийн хөрвөх чадварын шаардлагыг чангатгах нь чухал болоод байна.

Дэлхий дахинд цахим валют өссөөр байна. Фэйсбүүкээс нэвтрүүлсэн Либра валют ихээхэн анхаарал татаж байгаа. Та Либраг юу гэж бодож байна вэ?

Либра бол санхүүгийн түүхэн дахь онцгой үйл явдал. Анх удаа хувийн санаачилсан мөнгөн гүйлгээ асар их хандалтыг авч чадсан.

Улс төрийн хүчтэй эсэргүүцэл дунд энэ нь маш зөөлнөөр гарч ирж чадсан.

Либра төдийгүй Биткойн болон бусад санхүүгийн инноваци нь Төв банк орчин үеийн төлбөрийн системийн талаар анхаарах цаг болсныг сануулж байна. Либра нь мөнгөний үүргүүд болох хуримтлал, төлбөрийн хэрэгсэл, өртгийн хэмжүүрийг илэрхийлж чадах үедээ үнэ цэнтэй болно. Аливаа улсын валют нь эдгээр үүргүүдийг гүйцэтгэж чаддаг бөгөөд Төв банк ч баталгаажуулж байдаг. Либрад санхүүгийн маш олон тодорхойгүй асуудлууд байсаар л байна. Тийм учраас энэ нь газар авахгүй байгаа юм.

Илүү суурь зарчмын зүйл асууя л даа: Мөнгө нь зөвхөн улсаас гүйлгээнд гаргах ёстой нийтийн өмч байх ёстой юу? Энэ нь энгийн зах зээлээс хэр ялгаатай вэ?

Миний бодлоор мөнгө бол нийтийн өмч мөн. Аливаа улс орны мөнгөн тэмдэгт зөвхөн итгэмжит, зөвшөөрөгдсөн байгууллагаар дамжуулан хэрэгцээтэй хэмжээгээр тодорхой хамгаалалтын элементтэйгээр гүйлгээнд оруулах шаардлагатай байдаг. Энэ нь тухайн валютын үнэ цэнийг тогтвортой байлгахад нөлөөлдөг. Либрагийн хувьд үнэ цэнэ нь үнэндээ тухайн улсын мөнгөн тэмдэгтээр баталгаажна.

Зах зээлийн өрсөлдөөн нь илүү үнэ цэнтэй валютыг бий болгоно гэж энэ төрлийн валютыг дэмжигчид үздэг.

Дэлхийн эдийн засагт ихэнх улсын валют хэвийн байна. Эсвэл Швейцарын франкт асуудал байна уу?

Тийм зүйл байхгүй. Эргэлзээгүй өрсөлдөөн чухал. Ялангуяа, дотоод гадаадын гүйлгээг хялбаршуулах зорилгын хүрээнд бүр ч хэрэгтэй. Эндээс л өрсөлдөөн эхэлдэг. Ийм үед Либратай ижил инновациуд маш томоохон өөрчлөлтүүдийг бий болгох боломжтой. Тиймээс би хувьдаа энэ төрлийн төслүүдийг улс болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа гэж харж байгаа.

Төв банкинд хандах хүлээлт улам бүр л нэмэгдэж байна. Зөвхөн үнийн тогтвортой байдлыг хангах нь хангалттай биш болоод байна. Харин санхүүгийн тогтвортой байдал, ажлын байрыг хангах, цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, нийгмийн хуваарилалтын асуудлуудыг зохицуулах зэрэг олон зүйлийг шаардаж байна. Энэ нь мөнгөний бодлогод хэт хүнд ачаа мэт сонсогдож магадгүй.

Тийм ээ, хүлээлт их бий. Төв банк зарим зүйлийг хангаж чадах боловч бүгдийг хийх боломжгүй. Зарим газруудад мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгслүүд нь дутмаг байдаг. Үүнийг үнэнээр нь хэлэх л хэрэгтэй.

Эх сурвалж: <https://www.bis.org/speeches/sp201010.htm>

Орчуулсан: Э.Золзаяа (ОНБМТ-ийн ХА-ны мэргэжилтэн)

СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ ГУРАВДАГЧ УЛС ОРНЫ ЖАГСААЛТ БА МОНГОЛ УЛС

Б.Баярсайхан¹

JEL ангилал:	Хураангуй:
D73, K42, P37	
Тулхуур үг:	Европын комиссоос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд стратегийн дутагдалтай гуравдагч улсын жагсаалтыг гаргасан ажээ. Энэхүү жагсаалтад Монгол Улсыг оруулсантай холбоотойгоор түүний үндэслэл, шалгуур, үр дагавар болон холбогдох талын байр суурийг авч үзэж дүгнэлт хийлээ.
Стратегийн дутагдалтай улсын жагсаалт; мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх; Европын комисс	Жагсаалтад оруулах үндэслэл, талуудын байр суурийг харахад, Европын комиссоос гаргасан жагсаалтад улс орнуудыг хамруулахдаа хэт нэг талыг барьсан, мөн тэдгээрт урьдчилан мэдэгдээгүй, хамгаалах боломж олгоогүй зэрэг шүүмжлэл давамгайлж байна.

Удиртгал

Европын комиссоос “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд стратегийн дутагдалтай гуравдагч улсын жагсаалт”²-ын төслийг гаргасан билээ. Уг жагсаалтад Монгол Улсыг оруулсантай холбогдуулан баримталсан шалгуур, түүний үндэслэл, жагсаалтад ороход үүсэх үр дагаварын талаар авч үзлээ. Түүнчлэн энэхүү жагсаалтын талаарх талуудын байр суурь, бусад ижил төстэй жагсаалтын талаар энэхүү нийтлэлд судаллаа.

1. Европын комиссын шийдвэр

Европын комиссоос 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээг бэхжүүлэх зорилгоор дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар Европын холбооны цогц бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд стратегийн дутагдалтай гуравдагч улсыг тодорхойлох шинэчилсэн аргачлал;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд стратегийн дутагдалтай гуравдагч улсын жагсаалтын төсөл (үүнд Монгол Улс орсон).

Дээрх төслийг Европын комиссоос боловсруулсан бөгөөд улмаар эцэслэн батлуулахаар Европын парламент, Европын зөвлөлд шилжүүлээд байна.

Эдгээр байгууллага 1-2 сарын хугацаанд хянан хэлэлцээд дэмжвэл уг шийдвэр албан ёсны сэтгүүлд хэвлэгдэж, мөрдөгддөг байна.

Шалгуур

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд стратегийн дутагдалтай гуравдагч улсын жагсаалтыг гаргахдаа дараах шалгуурыг баримталсан ажээ.

Техникийн шалгуурыг Европын холбооноос 2015 онд баталсан “Мөнгө угаахтай тэмцэх дөрөвдүгээр удирдамж”³-аар тодорхойлж, улмаар шалгуурыг илүү боловсронгуй болгон

³ 4th Anti-Money Laundering Directive.

¹ АТГ-ын Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан. Цахим шуудан: bayarsaikhan@iaac.mn

² Third countries which have strategic deficiencies in their AML/CFT regimes.

шинэчилж, Мөнгө угаахтай тэмцэх тавдугаар удирдамжийг 2018 онд баталжээ. Гишүүн улс орнууд уг удирдамжид 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр гэхэд шилжсэн байх ёстой.⁴ Удирдамжийн дагуу Европын комиссоос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, институцийн хүрээнд стратегийн дутагдалтай гуравдагч улсыг тодорхойлохдоо дараах шалгуурыг баримталжээ. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцож буй байдал;
- Санхүүгийн систем дэх хэрэглэгчийн талаарх мэдээллийг нягтлан шалгах болон холбогдох бүртгэлд тавигдаж буй нөхцөл шаардлагын түвшин;
- Сэжигтэй гүйлгээг мэдээлэх үйл ажиллагаа;
- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл авах, солилцох байдал;
- Холбогдох байгууллагын эрх хэмжээ, процедур;
- Олон улсын хамтын ажиллагааны туршлага;
- Шийтгэл, хариуцлагын тогтолцооны үр дүнтэй байдал зэрэг болно.

Үнэлгээг гаргахдаа холбогдох олон улсын байгууллагаас гаргасан үнэлгээ, тайлан болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан стандартыг баримталдаг байна.⁵

Жагсаалтыг шинэчлэн гаргах давтамж

ФАТФ-ын жагсаалтыг Европын комиссын хувьд суурь түвшин гэж үздэг тул Европын холбооны жагсаалтыг ФАТФ-ын жагсаалт шинэчлэгдэн гарснаас хойш нэг сарын дараа шинэчлэн гаргадаг.

Үүнээс гадна одоо гарч буй шинэчилсэн аргачлалын дагуу Европын комиссоос өөрийн бие даасан үнэлгээнд үндэслэн гуравдагч улсыг тодорхойлно. Мөн Европын комиссоос өөрийн

⁴ https://ec.europa.eu/info/business-economy-euro/banking-and-finance/financial-supervision-and-risk-management/anti-money-laundering-and-counter-terrorist-financing_en.

⁵ https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/qanda_20_821

стратегийн дутагдалтай байдалд анхаарал хандуулах амлалтаас татгалзсан, эсхүл эрсдэлийн түвшин өндөр байгаа улс орныг нэн даруй жагсаалтад оруулдаг.

Түүнчлэн Европын холбооны бие даасан үнэлгээний хүрээнд өөрийн асуудалдаа анхаарал хандуулах амлалт өгсөн гуравдагч улс орон ажиглалтын 12 сарын хугацааг авах боломжтой. Харин дээрх хугацаанд амлалтаа биелүүлээгүй бол жагсаалтад оруулахаар заажээ.

ФАТФ болон Европын холбооны жагсаалтын уялдаа

Зарчмын хувьд ФАТФ-ын эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтад орсон улсыг Европын холбооны жагсаалтад оруулна.

Харин ФАТФ-ын жагсаалтаас хасагдаж байгаа улсыг Европын холбооны жагсаалтаас хасах эсэхийг Европын комиссоос үнэлгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэдэг байна.

Европын комиссоос гаргасан жагсаалтын үндэслэл

Европын холбооноос баталсан Мөнгө угаахтай тэмцэх дөрөв болон тавдугаар удирдамжид зааснаар Европын холбооны санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү жагсаалтыг гаргадаг.

Үүний дагуу өндөр эрсдэл бүхий гуравдагч улсыг тодорхойлох чиг үүргийг Европын комисс гүйцэтгэдэг. Европын комиссоос энэ жагсаалтыг анх 2016 онд гаргаж, үүнээс хойш удаа дараа шинэчилж ирсэн байна.

Мөнгө угаахтай тэмцэх тавдугаар удирдамж 2018 онд батлагдсанаас хойш гуравдагч улсыг тодорхойлох шалгуурыг өргөжүүлжээ. Үүнтэй холбоотойгоор Европын комиссоос хараат бус үнэлгээг зохион байгуулах, шинэчилсэн аргачлалын дагуу жагсаалт үүсгэх үе шатыг зохион байгуулах шаардлага үүссэн ажээ. Нөгөө талд бие даасан жагсаалт гаргахыг Европын парламентаас шаардсан ажээ.

ФАТФ-аас гаргасан жагсаалтад илүү нийцүүлэх зорилгоор Европын парламентаас эрх шилжүүлсний хүрээнд энэ удаа Европын

комиссоос өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хямралын нөхцөл байдалтай уялдуулан энэхүү жагсаалтыг ашиглах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх хугацааг 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөр тогтоосон нь нэг талаар цар тахлын нөхцөл байдалтай холбоотой боловч, нөгөө талаас холбогдох талуудад бэлтгэл хангах хугацаа болох аж.

Жагсаалтад орсон улс орнууд

Европын комисс жагсаалтыг гаргахдаа ФАТФ-аас гаргасан хамгийн сүүлийн жагсаалтыг харгалзан үзжээ. Үүний үр дүнд Европын холбооны жагсаалтад шинээр 12 улсыг нэмж, 6 улсыг хасах шийдвэр гаргасан байна (Хүснэгт 1).

ФАТФ-ын Нийцлийн баримт бичиг (Compliance documents)-т үндэслэн Европын комиссоос Европын холбооны 2015/849 дугаар удирдамжийн 9 (2) дүгээр зүйлийн дагуу Багамын арлууд, Барбадос, Ботсвана, Камбож, Гана, Ямайка, Мавритан, Монгол, Бирм, Никарагуа, Панам, Зимбабве улсыг жагсаалтад оруулжээ.

Эдгээр улс өөрийн стратегийн дутагдалтай байдлаа арилгахаар ФАТФ-тай тохиролцсоны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, үүнийгээ хэрэгжүүлэх талаар өндөр түвшинд улс төрийн үүрэг амлалтаа өгөөд байсан юм.

Европын комиссын зүгээс эдгээр улс оронд урьд нь өгч байсан амлалтыг нь эргэн сануулж шуурхай хэрэгжүүлж ажиллахыг уриалж байгаа ажээ.

Хүснэгт 1. Европын холбооны өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтад орсон, гарсан улсууд

№	Өндөр эрсдэл бүхий гуравдагч улс	Орсон огноо					Гарсан огноо
		2016/09/20	2018/01/24	2018/02/14	2018/10/02	(Алба-жаагүй)	(Алба-жаагүй)
1.	Афганистан	+					
2.	Барбадос					+	
3.	Босни Герцеговин	+					+
4.	Ботсвана					+	
5.	Камбож					+	
6.	Хойд Солонгос (БНАСАУ)	+					
7.	Этиоп		+				+
8.	Гана					+	
9.	Гайана	+					+
10.	Иран	+					
11.	Ирак	+					
12.	Ямайка					+	
13.	Лаос	+					+
14.	Мавритани					+	
15.	Монгол					+	
16.	Мьянмар					+	
17.	Никарагуа					+	
18.	Пакистан				+		
19.	Панам					+	
20.	Шри Ланк			+			+
21.	Сири	+					
22.	Багамын Арлууд					+	
23.	Тринидад Тобаго			+			

24.	Тунис		+		+
25.	Уганда	+			
26.	Вануату	+			
27.	Иемен	+			
28.	Зимбабве			+	

Эх сурвалж: Европын комиссын албан ёсны сайт: https://ec.europa.eu/finance/docs/level-2-measures/aml-delegated-act-2020-2801_en.pdf <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:02016R1675-20181022>

Жагсаалтаас гарах улс

Тодорхой хэмжээнд ахиц гаргаж стратегийн дутагдалтай байдлаа залруулсан гэж үзээд Босн-Херцеговина, Гайана, Лаос, Этиоп, Шри Ланк, Тунис улсыг жагсаалтаас гаргаад байна. Энэхүү шийдвэр нь албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш 20 хоногийн дараа хүчин төгөлдөр мөрдөгдөх юм.

Жагсаалтад орсны үр дагавар

Мөнгө угаахтай тэмцэх дөрөвдүгээр удирдамжийн дагуу холбогдох банк, бусад санхүүгийн байгууллагын зүгээс жагсаалтад багтсан өндөр эрсдэл бүхий гуравдагч улстай холбоотой гүйлгээнд нэмэлт хяналт тавьж, мониторинг хийнэ.

Мөнгө угаахтай тэмцэх тавдугаар удирдамжид зааснаар дээрх нэмэлт хяналтын хүрээнд хэрэглэгч, ашиг хүртэгч эзний талаарх нэмэлт мэдээлэл, бизнесийн харилцаа тогтоохтой холбоотой эрх бүхий этгээдийн зөвшөөрөл зэрэг мэдээллийг шаардах боломжтой.

2. Монгол Улсыг жагсаалтад оруулсан үндэслэл

ФАТФ-аас 2019 оны 10 дугаар сард Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой стратегийн дутагдалтай улс ("Саарал жагсаалт") гэж тодорхойлсон. Манай орон стратегийн дутагдалтай байдлаа арилгахын тулд ФАТФ-тай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байгаа билээ.

Дүгнэлт

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэл бүхий зарим улс орныг багтаасан жагсаалтыг Европын комиссоос гаргасан байна. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх боломжийг ихээр олгож байгаа оффшор бүсийг уг жагсаалтад бүрэн оруулахгүй байгаа нь хэт нэг талыг барьсан шийдвэр гэж үзэхэд хүргэж байна.

Европын комиссоос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд стратегийн дутагдалтай гуравдагч улсын жагсаалтыг гаргахдаа хэт нэг талыг барьсан, мөн улс орнуудад урьдчилан мэдэгдээгүй, хамгаалах боломж олгоогүй гэсэн шүүмжлэл давамгайлж байна.

Уг жагсаалтын талаар Европын холбооны байгууллагууд харилцан нэгдмэл бус байр суурьтай байсныг дурдах нь зүйтэй юм.

<https://caribbeantradelaw.com/2020/05/10/the-eus-updated-draft-aml-cft-list-of-high-risk-third-jurisdictions-take-tw>

ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Төлбөрийн систем

Төлбөр гүйцэтгэгчээс төлбөр хүлээн авагчид мөнгөн хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагаа, эрх бүхий байгууллага, техник технологи бүхий дэд бүтэц, мөрдөгдөх хууль тогтоомж болон төлбөрийн хэрэгслийн цогц нэгдлийг төлбөрийн систем гэнэ



Төлбөрийн системийн зорилго

Төлбөрийн системийн үндсэн зорилго нь системийн оролцогч хооронд хийгдэх төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангахад оршино.

Төлбөрийн хэрэгсэл

- Бэлэн мөнгө
- Интернэт банк
- Төлбөрийн даалгавар, нэхэмжлэл
- Мобайл банк
- Төлбөрийн карт
- Мөнгөн гуйвуулга
- Цахим мөнгө
- Биллинг

Олон улсад мөрдөгж буй нийтлэг зарчмууд

Олон улсын төлбөр тооцооны банкаас 2012 онд шинэчлэн гаргасан зарчимд нийцүүлэн төлбөрийн систем, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн жигд ажиллагааг хангахад Төв банкнаас баримтлах зарчим:

- Бодлого, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, шалгалт хийх.
- Зохицуулалт хийх, хяналт тавих, шалгалт хийх бүрэн эрх, нөөц бололцоотой байх.
- Төлбөрийн системийн бодлого, зорилгыг ил тод болгох.
- Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн стандартыг мөрдөх.
- Эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах.

Төв банк төлбөрийн системд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

- Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохион байгуулах: Төлбөрийн системийн оролцогч хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэж, үр дүнгийн тооцооллыг хийнэ.
- Төлбөр тооцоонд оролцох: Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ЗГ болон өөрийн нэрийн өмнөөс төлбөр тооцоо гүйцэтгэнэ.
- Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохицуулах, бодлого, журам, дүрмийг тодорхойлох:
- Төлбөрийн системд хяналт тавих, шалгалт хийх:
- Төлбөрийн системийг хөгжүүлэх, шинэчлэх

Монгол Улсын төлбөрийн системийн түүхэн хөгжил

1995 онд - Төлбөрийн хэрэгслийг хуульчлав.

1996 онд - SWIFT сүлжээнд холбогдов.

2006 онд - Үндэсний цахим гүйлгээний төвийг байгуулав.

2009 онд - Төлбөрийн картын нэгдсэн сүлжээг байгуулав.

2009 онд - Их дүнтэй төлбөрийн “Банксүлжээ” системийг нэвтрүүлэв.

2012 онд - Үндэсний брэнд ₮ карт гаргав.

2014 онд - Бага дүнтэй төлбөрийн систем 24/7, бодит цагийн горимд шилжив.

2016 онд - Банк хоорондын интернет худалдаа “eCommerce” нэвтрүүлэв.

2016 онд - Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлж эхлэв.

2017 онд - “Үндэсний төлбөрийн системийн тухай” хууль батлагдав.

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч



Банк, зөвшөөрөл бүхий Банк
бус санхүүгийн байгууллага,
ба Финтек компани

Хэрэглэгч



- Иргэд
- Хуулийн этгээд

Төлбөрийн системийн гээг бүтэц



ЗАЛИЛАГЧИД БОЛОМЖ БҮҮ ОЛГО

ЗӨВХӨН ТАНД ЗОРИУЛСАН УРАМШУУЛАА
ДООРХ ЛИНКЭЭР ОРООД ХУДАЛДАН АВАЛТАА ХИЙГЭЭРЭЙ.



ЭНД ДАРНА УУ



Анхаарал татахуйц, сэжиг бүхий мэдээ мэдээлэл,
зар сурталчилгааны холбоос линк дээр дарахгүй байж,
цахим залилангаас өөрийгөө хамгаалаарай.

ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ!





ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ!



Улаанбаатар хот
2020.10.26-2020.11.27